

**ТӨСВИЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны тооч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-31

-
- 1. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд
байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-
ийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр 3-31
ирүүлсэн, зөвшилцөх/**
-

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын
хамтарсан 10 дугаар сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 56 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 53.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилоттой: Х.Жангабыл, Д.Цогтбаатар;
Чөлөөтэй: Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, Т.Аубакир, Б.Жаргалан, С.Лүндэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр;
Тасалсан: О.Амгаланбаатар, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Н.Батсүмбэрэл, Д.Ганбат, Л.Гантөмөр, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Х.Тэмүүжин, Б.Түвшин, Б.Энхбаяр.

**Нэг.Монгол Улс болон Азиин хөгжлийн банк хооронд байгуулах
“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2025.09.01-
ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантоогох, мөн хэлтсийн мэргэжилтэн У.Марал, Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандуулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Хөтөлбөрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Д.Бум-Очир, Ж.Батжаргал, Г.Хосбаяр, Л.Энхнасан, Ч.Номин, Б.Тулга, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Ж.Энхбаяр, Ч.Номин, П.Наранбаяр, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 14
Бүгд: 35
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг хэллэлцсэн талаарх Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Үг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 41 минут үргэлжилж, 56 гишүүнээс 35 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 08 минут.

**ТӨСВИЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсвийн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн байна. Та бүхэнд ирцийн мэдээг танилцуулъя.

Норовын Алтанхуяг гишүүн хүрэлцэн ирсэн байна. Чинбаатарын Анар гишүүн, Ринчэндоржийн Батболд гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жадамбаагийн Баясгалан гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн, Батжаргалын Заябал гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Чинбатын Номин гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Баттогохын Чойжилсүрэн гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Жадамбаагийн Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг ирц бүрдсэн байна.

Ингээд Төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн тул 2025 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх 1 асуудал байгаа.

Монгол Улс болоод Азийн хөгжлийн банкны хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгоо ё.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад холбогдох албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулъя. Засгийн газраас өнөөдөр орж ирж асуудлыг танилцуулж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Сангийн яамнаас Сангийн сайд Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Марал гэсэн ийм бүрэлдэхүүн Сангийн яамнаас оролцож байна. Эрүүл мэндийн яамнаас тус зээлийн хэлэлцээртэй холбогдуулаад

Эрүүл мэндийн сайд Чинбүрэн, мөн Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Хүрэлбаатар гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Боловсролын яамнаас уг зээлийн хэлэлцээртэй холбогдуулаад Боловсролын сайд Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал хүрэлцэн ирсэн байна. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хурандаа Ариунбуян хүрэлцэн ирсэн байна. Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч Мөнх-Эрдэнэ, Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Баянмөнх гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байгаа юм байна.

Ингээд Монгол Улс болоод Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдыг микрофонд урьж байна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хүн бүр чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх, эрүүл мэндийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, гамшигаас сэргийлэх үндэсний болон орон нутгийн чадавхыг бэхжүүлж, гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгох зорилтуудын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дараах 4 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

1-д Засгийн газраас 2026 оныг боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбоотойгоор боловсролын салбарт тулгамдаж буй сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын анги дүүргэлтийг бууруулж, хүүхэд багачуудын суралцах орчныг сайжруулах зорилгоор 130 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 31 сургууль, 9 цэцэрлэг барьж байгуулах. Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн 2 дахь үе шат.

2-т техникийн болон мэргэжлийн боловсролын чанарыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, ажиллах хүчиний хомсдол үүсээд байгаа салбаруудад чиглэсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор 20 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тогтолцоог орчин үеийн технологид суурилан бэхжүүлэх. Монгол Улсын ажиллах хүчиний ур чадварыг хөгжүүлэх төсөл.

3-д улсын хэмжээнд яаралтай болон эрчимт эмчилгээний дэд бүтцийг өргөжүүлэн шинэчлэх, хот, хөдөөгийн ялгааг арилгаж, түргэн тусlamжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 225 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр аймгуудын эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх төсөл

4-д гамшигийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх онцгой байдлын байгууллагын гай гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор 100 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр Монгол Улс дахь гамшигийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төслийг санхүүжүүлэхээр тус тус төлөвлөөд байна.

Азийн хөгжлийн банктай байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн зээлийн ерөнхий нөхцөлийн хувьд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн зээл нь тогтмол 2 хувийн хүйтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Энгийн эх үүсвэрийн зээл нь 4,8 хувийн хөвөгч хүйтэй, 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд 0,15 хувийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэлтэй болно.

“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг байгуулснаар Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсад олгох зээлийн эх үүсвэрийг баталгаажуулж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх юм.

“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар, 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцэж, дэмжсэн бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, гэрээний төсөл, танилцуулга, материалыг та бүх хүнд хүргүүлсэн болно.

Та бүхэн гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төсөлтэй танилцан хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайдад баярлалаа. Ингээд зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Очирбат танилцуулна. Очирбат гишүүнийг микрофонд урьж байна.

Г.Очирбат: Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг Улсын Их Хурлын холбогдох байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 29, 10 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаараа дээрх зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-дэх хэсэгт заасныг баримтлан хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хүн бүр чанартай боловсрол эзэмших, эрх, тэгш боломж бүрдүүлэх, эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, гамшигаас сэргийлэх үндэсний болон орон нутгийн чадавхыг бэхжүүлэх, гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгох зорилтуудын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй болон энгийн эх үүсвэртэй зээлээр дараах 4 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж, зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхөөр ирүүлжээ.

1 дүгээрт боловсролын салбарт тулгамдаж байгаа сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын анги дүүргэлтийг бууруулж хүүхэд багачуудын суралцах орчныг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг барьж байгуулах,

2 дугаарт техникийн болон мэргэжлийн боловсролын чанарыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, ажиллах хүчний хомсдолыг үүсээд байгаа салбаруудад чиглэсэн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтолцоог орчин үеийн технологид суурилан бэхжүүлэх,

3 дугаарт Монгол Улсын хэмжээнд яаралтай болон эрчимт эмчилгээний дэд бүтцийг өргөжүүлэн шинэчлэх, эрүүл мэндийн салбар дахь хот, хөдөөгийн ялгааг арилгах, түргэн тусlamжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулж эрчимжүүлэх,

4 дүгээрт гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх, онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улс дахь гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төслийг санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Зээлийн хэлэлцээрийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд тус зээлийн хөрөнгөөр барьж байгуулах, сургууль, цэцэрлэгийн төсөвт өртгийг зөв тооцож, оновчтой төсөвлөсөн эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн хэрэгжүүлэхээр тусгасан төслүүдийн зорилго, арга хэмжээ, байршуудыг хэрхэн, ямар аргачлалаар сонгосон, нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдолтой байдлаар хэрхэн эрэмбэлсэн талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа гэрээний дагуу гүйцэтгэгч талаас нийлүүлэх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үнийн мэдээлэл, судалгааг хэрхэн хийсэн талаар, орон нутагт барьж байгуулах сургууль, цэцэрлэгийн чанар хүртээмжийн байдлыг тухайн аймгийн хүн ам, суралцагчдын тоонд хэрхэн харьцуулж оновчтой хуваарилсан талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга мэргэжлийн болон техникийн боловсон хүчний чадавхыг сайжруулах чиглэлээр 20 сая ам.доллар хуваарилсныг зөвхөн хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулж байгаа нь оновчтой эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга алслагдсан сумд хилийн боомтуудын эмнэлгийн яаралтай болон эрчимт эмчилгээний чанар хүртээмжтэй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат зээлийн хэлэлцээрийн ерөнхий нөхцөлийн хувьд энгийн эх үүсвэрийн зээлийн хүүг хөнгөлөлттэй эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжтой эсэх талаар, боловсролын салбарт хэрэгжүүлэх сургалт цэцэрлэгийн барилгын төсөвт өртгийг нийслэл хот, алслагдсан аймгуудад хэрхэн тооцсон талаар, эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхдээ шинээр төслийн нэгжүүд байгуулах эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл төслийн хүрээнд боловсролын салбарт хийгдэх ажил, арга хэмжээ үр дүн оновчгүй байгаа талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц зээлийн эх үүсвэрээр барилга байшин барих, тоног төхөөрөмж худалдан авах зүйтэй эсэх, нийслэл хот, орон нутагт шинээр сургууль, цэцэрлэг барихдаа чанар, хүртээмжтэй байдал, анги дүүргэлтийг нарийвчлан тооцолгүй хуваарилсан талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд 2026 онд Монгол Улс гадаад өрийн хүүгийн төлбөрт 3,7 их наяд төгрөгийг төлөх хуваарьтай байгаа тул шинээр зээлийн хэлэлцээр байгуулахдаа үүнийг онцгойлон анхаарах талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх чадавхыг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хэрхэн хангах талаар, яаралтай болон эрчимт эмчилгээний дэд бүтцийг алслагдсан сумдад тэгш хүртээмжтэй байдлаар хуваарилж байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй болон энгийн эх үүсвэртэй зээлээр санхүүжүүлэх 4 төслийн зорилго, арга хэмжээ, байршил, үр дүнг дахин нарийвчлан эрэмбэлж, нийгэм, эдийн засгийн үр дүнтэй суурилсан байдлаар хуваарилах, үүний тулд шинээр барихаар төлөвлөсөн сургууль, цэцэрлэгийн байршуудыг дахин оновчтой хуваарилах талаарх саналыг Засгийн газарт хүргүүлж, зээлийн хэлэлцээрт тусгах нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцэхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хооронд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал хандуулсан эрхэм хүндэт гишүүд, Байнгын хорооны дарга та бүхэндээ баярлалаа.

Г.Тэмүүлэн: Очирбат гишүүнд баярлалаа. Ингээд 2 Байнгын хорооны гишүүд маань зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асууна. Асуулт асуух гишүүдийн нэrsийг авъя. Бум-Очир гишүүнээр тасаллаа. Ингээд Үүрийнтуяа гишүүн асуулт асууна.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Надад 2 асуулт байна.

1 дүгээрт энэ зээлийн хэлэлцээр дотор байгаа нэг багц асуудал нь 20 сая долларын асуудал байгаад байгаа юм. Хүний хөгжлийн 20 сая доллар. Энэ хүний хөгжлийн 20 сая долларыг ингээд доторх задаргааг нь аваад үзэхээр яг задалж нарийвчилсан хуваарилсан юм алга. Нэг нь бол хөдөө аж ахуйн чиглэлийн дахин нэг жишиг сургууль байгуулна гээд. Энэ өөрөө Боловсролын яамны харьяа асуудал биш үү.

Дараа нь нэг тогтолцоо хөгжүүлэх тухай асуудал яригдаад байгаа юм. Яг юунд зарцуулах гэж байгаа юм. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн боловсон хүчинийг бэлтгэж байгаа ХААИС өөрөө хөдөө аж ахуйн боловсон хүчинээ бэлтгэхээ больчихсон. Яагаад гэхээр энэ чиглэлээр нь сурдаг хүн байхгүй болсон. Хөдөө аж ахуйн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчинийг бодлогоор бэлтгэж чадахаа больсон. Үндсэндээ ХААИС-ийн оюутнуудын дийлэнх нь эдийн засаг, менежментийн чиглэлийн ерөнхий мэргэжлийн чиглэлийн болж хөдөө аж ахуй чиглэл рүүгээ мэргэшихээ больчхоод байгаа энэ үед энэ сургуулийнхаа нөөц бололцоог ашиглахгүй юм уу. Дахиад ямар сургууль барих гэж байгаа юм. Барилга бариад энэ салбар явах юм уу. Тэгээд тэр тусмаа зээлээр.

2 дахь асуулт Сангийн яам энэ зээлийн хэлэлцээр дээр яг хүүгийн зардал, санхүүгийн зардал, зээл авч байгаа өртөг өөрөө хэд вэ. Бид эргэн төлөх хугацааны эцэст энэ нийт санхүүжилтийн авч байгаа зээлийнхээ дүнг хэд болгож төлөх юм бэ. Энэ дүнг тодорхой хэлээд өгөөч.

Г.Тэмүүлэн: Үүрийнтуяа гишүүний асуултад хариульяа. Эхлээд Наранбаяр сайд, дараа нь Сангийн яам. Наранбаяр сайдын микрофоныг өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Үүрийнтуяа гишүүний асуултад хариульяа. Энэ бол Азийн хөгжлийн банкны 20 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх доторх задаргааг нь харах юм бол төвийн бүсэд Политехник коллежийг барихад 16 сая доллар, хөдөө аж ахуйн ажиллах хүчнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулахад 0,6 сая, хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээ хийхэд 0,5, магадалшгүй ажлын зардал гэж 2,3 сая доллар нийт 20 сая гэж тооцоолсон байгаа. Энэ сургууль нь бол өөрөө төвийн бүсэд Политехникийн коллеж байгуулснаараа хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх, ухаалаг технологи, инновацыг нэвтрүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын төрөлжсөн жишиг сургалтын тогтолцоог хөгжүүлэх ийм зорилготой байгаа. Ингэснээрээ хөдөө аж ахуйн ажлын байрны эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ техник технологийн ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн уялдааг хангахад мөн холбогдох талуудын хамтын ажиллагаа, түншлэлд сууринсан салбар дундын зохицуулалтыг бий болгоход зорьж байгаа. Тэгэхээр Хөдөө аж ахуйн их сургууль дээр үнэхээрийн бэлтгэгдэж байгаа боловсон хүчин цөөрч байгаа. Яг голлох юнууд, ялангуяа газар тариалан тал дээрээ элсэлт нь эрс буурсан ийм нөхцөл байдал үргэлжилсээр байгаа.

Тэгэхээр бид бас ер нь бол сургалтыг аль болохоороо инновацын техник технологи дамжуулах ийм сургалт руу чиглүүлэх, 2 дугаарт нь бол яг ийм Политехникийн коллеж ийм коллежаар дамжуулж, ялангуяа богино хугацаанд хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргах ийм шаардлагатай байгаа гэдгийг бол хаана хаана хүлээн зөвшөөрч байгаа.

Ийм учраас ийм чиглэлийн өөрөөр хэлбэл хосмог сургалтыг нэвтрүүлэх боломжтой мэргэжлийн боловсролын ийм сургалтын байгууллагуудыг байгуулах нь зүйтэй, түлхүү байгуулж тэнд бол богино хугацаанд бэлтгэгдсэн боловсон хүчин хөдөө аж ахуй дээр шууд ажиллахуйц өөрсдийнхөө бизнесийг эрхлээд явж болохууцаар болгож авах ёстой гэж үзэж байгаа.

Бид бас Дархан-Уул аймаг дээр бас ийм технологи техникийг дамжуулах ийм төвийг байгуулах судалгааг бол эхлүүлсэн байгаа. Богино хугацаанд хосмог сургалтаар олон ийм мэргэжилтэн бэлтгэхийг хөдөө аж ахуй биднээс шаардаад байгаа. Өнөөдөр хөдөө аж ахуй маш их техникужиж байна. Ай ти-ийн ололтуудыг өөртөө нэвтрүүлж байна. Энийг нь эзэмшсэн, богино хугацаанд бэлтгэгдсэн боловсон хүчин хэрэгтэй байгаа учраас энэ төслийг энэ дотор шингээж оруулсан гэж ингэж үзэж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сангийн яамнаас Үүрийнтуяа гишүүний асуултад хариулах уу. 9 номер. Албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулаарай.

С.Тулга: Сангийн яам Тулгаа гишүүний асуултад хариульяа. Азийн хөгжлийн банкнаас авч байгаа 475 сая ам.доллар нь 2 эх үүсвэрээс бүрдэж байгаа. 1 нь бол хөнгөлөлттэй эх үүсвэр. Энэ нь бол 243,8 сая доллар байгаа. Энэ дээр бид нар жилд тогтмолоор 2 хувийн хүү төлж байгаа. Нөгөөдөх нь л энгийн эх үүсвэр 231,2 сая ам.доллар. Энэ дээр бид нар софер дээр нэмэх нь 0,6 хувь. Тэгээд ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл дээр хөрөнгө баталгаажуулсны төлбөр гээд 0,15 хувийн төлбөр төлж байгаа. Одоогийн бид нарын төсөвлөж байгаа эргэн төлөлтийн тооцоогоор хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөрт энэ төслийн хугацаанд нийт 793 мянган ам.доллар төлөхөөр тооцоолсон байгаа. Хүүгийн төлбөрт бол бид нар хүүг зээлийн ашиглалттай уялдуулж төрдөг. Хэдий хэмжээний ашиглалт гарна төдий хэмжээний

хүү төлөхөөр байгаа. 2031 онд төсөл маань зээлийн ашиглалт бүрэн хийгдэж дуусахаар хамгийн өндөр жилдээ 15,7 сая доллар..../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 9 номер нэмж минут өгье.

С.Тулга: Ингээд 2026-2050 оны хооронд нийт 25 жилийн хугацаанд 197,7 сая ам.долларын хүү төлнө гэсэн ийм тооцоололтой байгаа.

Г.Тэмүүлэн: Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя. Үүрийнтуяа гишүүний микрофоныг өгье.

Д.Үүрийнтуяа: Наранбаяр сайд аа, би сургууль хэрэгтэй, мэргэжилтэн бэлтгэх хэрэгтэй гээд яриад байгааг чинь л харин хэлээд байгаа юм л даа. Мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ байна уу. Байна. Бидэнд сургуулийн бааз боловсон хүчнийг бэлтгэх тэр бааз суурь нь байна шүү дээ. ХААИС байна. ХААИС чинь үндсэндээ бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна шүү дээ. Үйлдвэрээр аваад үзэх юм бол мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг энэ үйлдвэрлэлийн процесс нь алдагчихаад байна шүү дээ. Тэгээд энийгээ ашиглахыг бодохгүй, дахиад зээлээр барилга барина гээд байдаг нь ямар учиртай юм бэ. Тэгээд төвийн бүсэд гэнэ. Их, дээд сургуулийнхаа хажууд нөөц боловсон хүчнийг нь ашиглаад мэргэжлийн ажилчдаа бэлтгэх боломжийг нь олгож болдоггүй юм уу. Яагаад энийг эрэлхийлэхгүй байгаа юм бэ гэдэг дээр. Би яг энэ асуудлаар өмнө нь бас танд ХААИС-ийн асуудлаар хэн нь энэ мэргэжлийн салбаруудаа авч явах юм бэ гэдэг дээр бас хэлж ярьж байсан даа.

Г.Тэмүүлэн: Нэмэлт асуултад Наранбаяр сайд хариуулъя.

П.Наранбаяр: ХААИС-ийн элсэлтийг нэмэгдүүлэх, тэнд бэлдэж байгаа боловсон хүчнийг чадавхжуулах шаардлага бол үнэхээрийн байгаа. Тантай санал нэг байна. Энэ чиглэлээр бас бид энэ элсэлтийг нэмэгдүүлэхийн тулд жилд 2 удаа элсэлт авхуулдаг болгосон. Хийж байгаа зүйлүүд бас нэлээн бий. Сүүлийн үед бас элсэн нь сэргэж ирж байгаа гэсэн ийм мэдээтэй байгаа. Яах вэ энэ төвийн бүсэд хөдөө аж ахуйн төрөлжсөн сургалт, дэд бүтэц бүхий ийм жишиг политехник коллежийг байгуулснаараа мах болон сүүний үхрийн аж ахуйн технологи, мал үржүүлэг, бэлчээр ашиглалт, нөхөн сэргээлт, тэжээл тариалалт гэх мэт 1900 орчим мэргэжилтэй боловсон хүчнийг бол 35 мэргэжлийн чиглэлээр жилдээ 1900 орчим мэргэжилтнийг бэлдэх ийм зорилготой байгаа. ХААИС ч гэсэн өөрийнхөө харьяанд бас Политехникийн коллежтой ингэж хоршсон хэлбэрээр хөгжинө гэж ингэж харж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Үүрийнтуяа гишүүн нэмж тодруулъя. Хоёулаа 1 л ойлголцохгүй л байна даа. Би бол ХААИС-ийн бодлогын асуудлыг танаас асуугаад байгаа юм биш шүү дээ. Бид энийг яриад л байгаа. ХААИС дээр бид мэргэжлийн ХААИС ч ялгаагүй, ШУТИС ч ялгаагүй энэ мэргэжлийн боловсон хүчнийг мэргэжлийн их, дээд сургуулиуд нь бэлддэг асуудал дээр бид нар бодлогын уялдаа холбоо алдагдаад байна. Өмчлөлийн хэлбэрээсээ, удирдлагын хэлбэрээсээ хүртэл хамаараад. Энэ нөөц боломжоо ашиглахгүйгээр нэмж зээл авах ямар хэрэгтэй юм бэ. Та сая хэллээ шүү дээ. ХААИС-ийн салбар коллежууд мэргэжил сургалт, үйлдвэрийн төвүүд орон нутагт байж байгаа байхгүй юу. Тэгвэл зах зээлийн багтаамжаа та хэд яаж судалсан юм. Хэчинээн хүн сурх юм. Хэдэн хүүхдийг сургах юм жилд. Хэчинээн мэргэжилтэн бэлтгэх гэж байгаа юм. Ийм тооцоо судалгаа байгаа юм уу. Яагаад төвийн бус сонгогдсон юм. Тодорхой мэдээлэл авмаар байна.

Г.Тэмүүлэн: Наранбаяр сайд хариулья.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгхээр энэ дээр бол ХААИС-ийн энэ жилийн элсэлтийн тоог манайхан тэндээс тодруулаад хэлээрэй. Ер нь сүүлийн үед хөдөө аж ахуй дээр ажиллаж байгаа хүмүүсийн өнөөдөр энэ техник технологи урагшаа хөгжөөд, богино хугацаанд хурдтай бэлтгэх ийм шаардлагатай байгаад байгаа учраас л ингэж байгаа юм. Төвийн бус сонгогдсон нь бол бүсчилсэн хөгжлөөрөө хөдөө аж ахуйн чиглэл рүүгээ төвийн бус илүү хүчтэй орж ирж байгаа. Энэ дээр бол төрөлжсөн янз бүрийн аж ахуйнууд, эрчимжсэн мал аж ахуй гээд төвийн бус дээрээ голлож байгаа учраас газар зүйн хувьд сонгогдсон гэж ингэж ойлгож байгаа. Ер нь бол хөдөө аж ахуйн чиглэлээр бид богино хугацаанд заавал хүнийг 4 жил сургах биш, богино хугацаанд 1-3 жилийн хугацаанд хүнээ бэлдэж гаргаж, бизнес, хөдөлмөрийн зах зээл дээр гаргах ийм шаардлага өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа учраас ийм бодлого барьж байгаа.

Г.Тэмүүлэн: Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нэг зүйлийг тодруулаад тийм боломж байдаг юм уу, үгүй юм уу асуучихмаар байгаа юм. Талбай дээр багш нар маань гарчихсан суулт хийж байгааг бид нар бүгдээрээ мэднэ. Улам хүйтрээд байдаг. Мэдээж энэ 130 мянган доллароор сургууль, цэцэрлэг барих гэж байгааг бол ойлгож байна. Бас дэмжиж байна. 2026 оны улсын төсөвт 448 тэрбум бас сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжид туссан байгаа. Миний асуух гэж байгаа зүйл юу вэ гэхээр би урьд нь бас хэлж байсан. Энэ 108 сургууль, 95 цэцэрлэг барьчихлаа гээд бodoход хүний нөөц нь хангагдахгүй байх юм биш үү. Одоо багш нар дутагдалтай байхад 108 сургууль, 95 цэцэрлэгт хэдэн багш хэрэгтэй болох юм. Тэрийгээ хаанаас нөхөх юм бэ гэдэг ийм асуудал байгаа.

Мэдээж хамгийн хангах боломж нь бол юу гэхээр багш нарынхаа цалинг нэмэх. Миний асуух гэж байгаа зүйл. Тэгхээр яг үүнтэй холбогдуулаад юу вэ гэхээр улсын төсөвт байгаа хөрөнгө оруулалтын 448 тэрбумаа цалин дээрээ өгөөд, тэр 448 тэрбумаа зээлээр шийдэх боломж байхгүй юм уу. Өөрөөр хэлбэл энэ сургууль, цэцэрлэгийн барилгын асуудлуудаа зээлээр шийдээд явах, нэгэнтээ төсөв хүрэхгүй байгаа учраас. Тэгээд төсөв дээрээ сургууль, цэцэрлэг дээрээ барилга дээр нь тавьчихсан байгаа мөнгөө багш нартаа оруулчих. Ингээд үзвэл 100 тэрбум гээд байж байгаа шүү дээ. Боловсролын сайд мэдэж байгаа. Тэр дээрээ энэ 448 тэрбумаа нэмчих юм бол 548 тэрбум болно. 548 тэрбумаараа багш нарынхаа цалинг нэмэх ийм бололцоо байхгүй байсан юм уу.

Яагаад вэ гэхээр 108 сургууль, 95 цэцэрлэгийг 2028 он хүртэл барина. Эхнээсээ баригдах цэцэрлэг, сургууль ашиглалтад ороод ирэнгүүт хүний нөөцийн асуудал нэхэгдэнэ. Тэгхээр бид нар хүний нөөцийн асуудал болоод сургууль, цэцэрлэгийн дутагдлын асуудлаа зэрэг шийдэж явахгүй бол сургууль, цэцэрлэгийн барилга барид байдаг, гэтэл тэн дотор нь суух сурагчид нь байгаад байдаг, багшгүй болчих юм биш үү. Тэгхээр энэ төсөв дээр тавьчихсан байгаа мөнгөө цалин дээрээ нэмээд, энэ дээрээ энэ 448 тэрбум орчим байсан санагдаж байна. Энийгээ гаднын зээл тусламжаар нөхөж авах ийм шийдэл байх боломжтой юу, үгүй юу гэдгийг асуумаар байна.

Г.Тэмүүлэн: Наранбаяр сайд Бум-Очир гишүүний асуултад хариулья.

П.Наранбаяр: Баярлалаа. Бум-Очир гишүүний ярьж байгааг маш сайн ойлгож байна. Ер нь бол цалин сайнгүй бол энэ салбар луу хүн орж ирэхгүй, багшийн дутагдал бол байнга байсаар байх нь ойлгомжтой. Бид энэ 448 тэрбум төгрөгийн 61 тэрбум нь бол сургууль, цэцэрлэгүүдийн тоног төхөөрөмжүүд, зөвлөн эдлэл эд нар гээд дотуур байрны тоног хэрэгслүүд байж байгаа юм. Тэгэхээрээ энэ 1 дүгээр явна. 2 дугаарт нь 200 гаруй он дамжаад, шилжчихсэн барилга байшиングуудаа дуусгах ийм голлох зарцуулалт нь тэндээ явна. Цалин нэмэх дээр бол энэ жил хувьсах зардлаар нь дамжуулаад, 100 тэрбумыг тусгасан. Мөн бас багш нар маань гадаа жагсаал, цуглаан, суулт хийж байна. Тэднийхээ дуу хоолойг сонсож байгаа. Өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нартай бас жагсагчдыг төлөөллийг уулзуулсан. Цаашдаа бид энэ багшийнхаа цалинг З жилд тогтвортой нэмэх ийм төлөвлөгөөгөө боловсруулаад, энийгээ мөрдөж ажиллахаар ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Бум-Очир гишүүн хариулт нь болсон уу. Батжаргал гишүүн асуулт асууяа.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Азийн хөгжлийн банкны 475 сая долларын санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр. Үүний хөнгөлөлттэй зээл, энгийн зээл 2-ын хоорондын харьцаа хэд юм бэ. Энэ дээр тодорхой хариулт авчихмаар байна.

2 дугаарт энэ боловсролын салбар, эрүүл мэндийн салбар, онцгой байдлын салбарууд дээр хийгдэх гэж байгаа мөнгөн дүнг бид хэрэгжих гэж байгаа төслийг дэмжиж өгч байгаа юм. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр хийгдсэний дараа байршил юмаа нарийсгаж тодруулж өөрчлөх бололцоо боломж гарах юм уу. Энэ дээр тодорхой хариулт авчихмаар байна.

Дараагийн нэг зүйл үнэхээрийн энэ мэргэжлийн боловсон хүчин, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх асуудал юу юунаас чухал байгаад байгаа. Үүнийг бид дэмжихээс аргагүй. Гэхдээ хөдөлмөрийн үнэлэмж бүтээмжийнхээ асуудлыг ер нь яаж тооцох юм бэ гэдэг л асуудал байгаад байгаа юм л даа. Тэрнээс тодорхой хүмүүст тодорхой хэмжээний чадамж бий болгох сургалт гэдэг юм уу, дадлагаар энэ асуудал шийдэгдэхгүй юм байна лээ. Энд бүтээмж ямар хэмжээтэй нэмэгдэж чадах юм, буцаад хөдөлмөрийн үнэлэмж нь ямар байх юм гэдэг юмыг том дүр зургаар нь бид замын зургаа зөв зурж байж энд асуудал зөв яригдах ёстой. Ингээд харах юм бол анхдагч үйлдвэрлэлээ дагасан боловсруулах үйлдвэрлэл чинь өөрөө дагаж бий болж, тэгээд нэмүү өртөг шингэж, өрсөлдөх чадвар нь нэмэгдэж, үнэ цэн орж байж л сая энэ бүтээмжийн чинь тухай ойлголт энэ хөдөлмөрийн үнэлэмж 2 чинь яригдаж гарч ирнэ. Үүнийгээ манай Засгийн газар ямархуу байдал тооцооллоор харж, энэ асуудлыг шийднэ гэж үзэж байна вэ гэдэг асуудал байна.

Манай гишүүдийн яриад байгаа зөв. Энэ байж байгаа хүчин чадал, үүний ашиглалтын байдал, үүнийг бүрэн гүйцэт ашиглах чиглэл рүү бид судалгаа, тооцоолол тухайлсан тэр хүчин чадал бүр дээрээ ямар зохицуулалт, ямар дэмжлэг хийж байж энэ үр дүнд хүрэх юм бэ гэдэг асуудлыг тооцсон юм байна уу. Энэ рүү бид ямар хэмжээний бодлого чиглэл явуулж, хөрөнгө санхүүгийн дэмжлэг, орчин нөхцөл сайжруулж байж үүнийг бий болгох юм. Энэ дээр Боловсролын яам ямархуу судалгаа тооцоолол байдаг юм. Үүнийгээ нэг тодорхой .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Минут авах уу. Батжаргал гишүүний асуултад хариульяа. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Батжаргал гишүүний асуултад хариульяа. Тэгэхээр ер нь бол энэ байршуудын асуудлыг хөндөж байна. Энэ сургууль, цэцэрлэг 41 байршил дээр өнөөдөр барихаар байгаа. Энэ бол бид нар бас газар зүйн яг мэдээллийн систем дээр үндэслээд, компьютер дээр яг тусгай программ ашиглаж, хүн амын нягтшил, хэрэгцээг нь судалсны үндсэн дээр эрэмбэлээд оруулж ирсэн байгаа. Гэхдээ өрөнхий хэлэлцээр Азийн хөгжлийн банктай байгуулсныхаа дараа бид бас энэ хэлэлцээрийг дахин харж үзэж, тусгай тусгай байршил болгон дээрээ хэлэлцээр хийгээд явна. Тэр үедээ бас зайлшгүй шаардлагатай гэсэн зүйлүүд дээр өөрчлөлт оруулах ийм боломж байгаа гэдгийг хэлье.

2 дахь асуулт нь юу билээ. Уучлаарай. Үр чадварын тухайд бол бид бас яг энэ Азийн хөгжлийн банкны энэ шугамаар явж байгаа хөдөө аж ахуйнхаа яг энэ политехник коллеж, түүнийг дагасан ур чадварын сургалтууд дээрээ бол бид бас тооцоолол хийж үзсэн. Энэ дээр бол бид бас Азийн хөгжлийн банкныхаа энэ төслөөр бид хөтөлбөрийн хүрээнд 2035 он гэхэд 28-30 мянган чадварлаг ажилтан бэлтгэх ийм боломжтой гэж харж байгаа байгаа. Ингэснээрээ бол жил бүр 500-535 сая ам.долларын ДНБ-ий өсөлт, сургалтын чанарыг сайжруулна гэж ингэж харж байгаа. 43-46 сая ам.долларын бүтээмжийн өсөлт бий болох боломжтой гэж.

Тэгээд бас мөн энэ төсөл дээр жижиг бизнес эрхэлж байгаа, ялангуяа эмэгтэйчүүдийг дэмжих ийм сургалтууд бас нэлэн явна. Түүний зэрэгцээ газар тариалан талдаа, хүнсний үйлдвэрлэл талдаа, малчид, бизнес эрхлэгчид, хоршооны гишүүдийн сургалтууд бол явна. Мөн бичил үйлдвэрүүд чадварт суурилсан ойролцоогоор 11 сургалтын хөтөлбөрийг бол малчид бизнес эрхлэгчдэд зориулж явуулах юм. Нийтдээ 39 хөтөлбөртэй ийм байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сангийн яамнаас хариульяа 9 номер. Зээлийн харьцаатай холбоотой асуудлаар.

С.Тулга: Сангийн яам Тулгаа гишүүний асуултад хариульяа. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн хувьд нийт зээлийн 51,3 хувь буюу 243,8 сая ам.доллар нь хөнгөлөлттэй зээл байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмж тодруулъяа.

Ж.Батжаргал: Үгүй ээ, би бол энэ санхүүжилтийн өрөнхий хэлэлцээрийг дэмжих талдаа байна. Энэ зөв. Үнэхээрийн өртөг ч хямд байна. Цаг хугацааны хувьд ч их боломжтой юм байна. Бас авч байгаа салбарууд маань үнэхээрийн авах ёстой салбарууд байна гэж.

Гэхдээ анхаармаар юмнуудыг бид судалмаар байна. Энэ өртгийн сүлжээ гэдэг юмаа ер нь яаж тооцож явах юм гэдэг нэг асуудал байгаад байгаа.

2 дугаарт энэ бодлого барьж байгаа яамнуудад нь энэ боловсон хүчин бэлтгэдэг гэдэг юм уу, ур чадвар бий болгодог асуудалдаа оролцох оролцоог нь бид яаж шийдэх юм бэ. Одоо баахан хүрээлэнгүүдийг аваачаад хэдүүлээ Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд аваачаад өгчихсөн. Зүгээр л орон тоо санхүүжүүлсэн ийм л үйл явц болчлоод байгаа. Гэтэл энэ улс ардын аж ахуйн салбар чинь бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн асуудлууд байгаад байдаг. Үүний захиалга, тэрүүнд гаргах хөрөнгө мөнгө, бүх юм орхигдож байгаа. Энийг одоо хэдүүлээ .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Сангийн яам хариулах уу. Өртөг, тооцоотой холбоотой асуудлууд дээр хэн хариулах вэ. 9 номер.

С.Тулга: Сангийн яам Тулгаа гишүүний асуултад хариулъя. Энэ хөнгөлөлттэй эх үүсвэрийн хувьд бол жилд тогтмолоор 2 хувийн хүүтэй, тэгээд 25 жилийн хугацаатай. Эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ийм нөхцөлтэй байгаа. Энгийн эх үүсвэр буюу 231,2 сая ам.доллар дээр софер дээр нэмэх нь 0,6 хувийн хүүтэй байгаа. Тэгээд ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл дээр 0,15 хувийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл төлөхөөр ийм нөхцөлтэй байгаа. Хугацааны хувьд мөн адил 25 жил, эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ийм өртөгтэй зээл байгаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн нэмээд тодруулъя.

Ж.Батжаргал: Угүй ээ, үгүй ингээд л байна л даа. Хэдүүлээ үнэхээрийн мэргэжлийн боловсролын чанарыг сайжруулах, ур чадварыг нэмэгдүүлэх, үүгээр дамжуулж бүтээмжийг бий болгох гээд л зориод байгаа бол энэ бүтцийн уялдаагаа зөв хиймээр байгаад байгаа юм. Уг асуудлаа хариуцаж байгаа салбарын яамнууд нь энэ үйл ажиллагаанд ямар эрх мэдэлтэй оролцох ёстой юм бэ гэдэг асуудал байгаад байхгүй юу. Тэгэхээр дан дамаа хөдөө аж ахуйн хөгжлийн асуудал ярьж байгаа бол Хөдөө аж ахуйн яам энэ мэргэжлийн боловсрол, хүрээлэнгүүдтэйгээ яаж ажиллах юм. Яаж тэр бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн захиалга юмнууд нь явах юм. Тэгээд тэрийг дагасан бүтээмжээр хөдөлмөрийн үнэлээмж яаж өсөх юм гэдэг асуудлуудаа шийдэхгүйгээр бид цаашаа явж чадахгүй юм байна лээ. Бүх сургууль гэдэг юм уу, бүх байгууллагууд дээр лаборатори дадлагын баазуудыг бий болгож чадахгүй. Тийм учраас тэр цахим одоо лабораториудыг нь бий болгоод, дадлагын баазуудыг нь .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан боловсон хүчнийг бэлтгэх, бэлдэж гаргах асуудал бол бид бас Хөдөө аж ахуйн яамныхаа захиалгыг авч, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тэр хөдөлмөрийн зах зээлийн судалгаатай уялдуулж, хүмүүсээ бэлддэг энэ тогтолцоо руу оруулна. Энэ дээрээ бас эрэлтээ тэргүүлэх ийм мэргэжлүүдээ Засгийн газраас 5 жил тутамдаа тогтоодог. Энийгээ шинэчлээд явна гэсэн үг. Зүгээр бидний харж байгаа тооцоогоор бол бид бас нэмэлтээр ийм 10 мянган чадварлаг ажиллах хүчин жил бүр эдийн засагт бол 170 сая ам.долларын өсөлт авч ирнэ гэж харж байгаа. Энэ Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хөтөлбөрийн хүрээнд бол 2035 он гэхэд 28-30 мянган чадварлаг ажилтан бэлтгэснээр бол 535 сая ам.долларын ДНБ-ий өсөлт сургалтын чанарыг сайжруулж чадна гэж ингэж харж байгаа.

Мөн ЖДҮ-ийн бизнесийг дэмжиж, ЖДҮ-ийн боловсон хүчнийг дэмжиж бий болгосноороо эдийн засгийн үр өгөөжийг илүү сайжруулна гэж харж байгаа. Монгол Улсын урт хугацааны өсөлт, өрсөлдөх чадвар, тогтвортой байдлыг хангахад бол ихээхэн ач холбогдолтой ийм төсөл болно гэж харж байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Ойрын үед Монгол Улсад 200 орчим сургууль, цэцэрлэг зайлшгүй шаардлагатай, барих шаардлагатай гэж судалгаа гарсан байгаа. Тэгээд тэрнийхээ

41 ширхгийг нь энэ Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр эхлүүлэх гэж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгээд яах вэ, 2026 оны төсвийн төсөл дээр боловсролын салбарт 15 шинэ сургууль, цэцэрлэгийн барилгын төсөв суудсан байгаа л даа. Тэгэхээр ер нь үлдсэн 150 орчим сургууль, цэцэрлэгийн барилга, энэ боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг ойрын хэдэн жилдээ яаж шийдэх төлөвлөгөө байгаа юм бэ. Ер нь нөгөө бид нарын яриад байгаа хувийн хэвшлээ дэмжих, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх зэрэг асуудлууд маань ер нь бодлогын түвшинд явж байгаа юу. Энэ төсвийг дагаад төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр яг хувийн хэвшлээ дэмжих, хувийн хэвшил сургууль, цэцэрлэг бариад улстайгаа түншлээд, түрээслээд ч юм уу ашиглах, магадгүй улсад зарах ч гэдэг юм уу, хүлээлгэж өгөх ч гэдэг юм уу ийм асуудлууд ер нь яригдаж байгаа юу.

Тэгээд энэ 130 сая долларын боловсролын салбарт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх төсөл маань хэрэгжих хугацаа нь 2026-2031 он гээд 5 жилийн хугацаатай тавьчихсан байна л даа. Тэгэхээр энэ 41 сургууль, цэцэрлэгийг 5 жилийн хугацаанд ийм урт хугацаанд барих юм уу. Одоо ер нь бид нар Монголынхоо энэ хувийн хэвшилд найдаж итгэж, эд нарыгаа жоохон дэмжихгүй бол болохоо байсан юм биш үү гэж. Хувийн компаниуд орон сууцын хоткон дотроо сургууль, цэцэрлэг барихаар 960 хүүхдийн сургуулийг ч 1 жилийн дотор барьчихаж байгаа. 100 хүүхдийн цэцэрлэгийг бол бараг 5 сарын хугацаанд барьчихаж байгаа юм. Гэтэл бид нар ингээд бодлогоор ч юм шиг ингээд санхүүжилтийг нь хэдэн жил хуваагаад тавьчихаар чинь нөгөө хувийн хэвшил чинь ч гэсэн тэр санхүүжилтдээ захирагдаад, удаан бариад байна л даа. Тэгэхээр уг нь энэ барилга байшингийн ажлыг чинь хурдан барих тусмаа л хувийн хэвшилдээ ч ашигтай, улсад ч гэсэндээ ашигтай ингээд асуудлуудаа шийдээд яваад байх ийм боломж байна л даа. Одоо хүн ам өсөж байгаа юм чинь сургууль, цэцэрлэг барих нь дамжиггүй шүү дээ. Бид цалин багш нарын цалин хөлснөөс гадна бас л энэ давхар сургууль, цэцэрлэгийнхээ барилгын асуудал, засварын асуудлыг ярьж л байх хэрэгтэй. Тэгэхээр энэ хувийн хэвшлээ дэмжих тал дээр ямар байгаа юм бэ. Энэ ийм урт хугацаанд хэрэгжих юм уу. Ер нь энэ санхүүжилтийг нь богино хугацаанд 1 жил, 2 жилд хуваагаад тавьдаг ийм бодлого байж болох уу. Сангийн яамнаас л асууна даа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Эхлээд Наранбаяр сайд. Шаардлагатай бол Сангийн яамнаас нэмээд тодруулаад хариулт өгөөрэй.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр бид энэ жил 41 сургууль, цэцэрлэгийг бол хөнгөлөлттэй зээлээр оруулж ирж байгаа. Хэдийгээр 2030 он гэсэн боловч ингээд ерөнхий хэлэлцээр нь байгуулагдаад эхэлчих юм бол ер нь бидний харж байгаагаар удлаа гэхэд 3 жил дотор бүгд баригдаад дуусна гэж харж байгаа.

Юуны хувьд бол бид ер нь гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх учраас 1 жилд барих ч тохиолдол гарна гэж харж байгаа. Төсөл бүрэн тайлагнаад, үр дүн гарах хугацааг л бичсэн байгаа. Ерөөсөө бүрэн дуусаад. Энэ дотор чинь бас нөгөө софт буюу ур чадвар сайжруулах төсөл ч бас байж байгаа учраас мэргэжлийн боловсрол дээр.

Хувийн хэвшил бол үнэхээрийн хурдан барьдаг. Сайн байдаг. Тийм учраас төр, хувийн хэвшлийн түншлэлийн саналыг бол Эдийн засаг, хөгжлийн яам руу явуулсан байгаа. Энэ төслийг л их зоригтой хэрэгжүүлж эхэлмээр байгаад байгаа юм. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр бэлэн барилгыг худалдаж авах, санхүүгийн түрээс аргаар худалдаж авах ийм ажлуудыг бол нэлээн эрчимжүүлмээр байгаа юм. Тэгэх

юм бол төсөвтөө ч тухайн жилдээ өртөг багатай, дарамт багатай, мөн нөгөө талдаа нэг барилга ашиглалтад орохыг хүлээх гэж 2-3 жил хүлээх ийм шаардлагагүй болж байгаа. Ийм сайн талууд байгаа.

Гэхдээ концессын хууль гэж гараад тэр концессын хуулиар олон жил дамнасан ийм муу түүхтэй ийм төслүүд байна. Дээр нь нэмээд хэт өндөр үнээр концессоор хийлгэсэн ийм муу түүх бас байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ дээр тэр талаасаа бас нэлээн болгоомжилж байгаа тал бий. Гэхдээ сүүлийн жилүүдэд Монголын өөрийн хувийн хэвшлүүд бол маш сайн барилга барьдаг болсон. Их чанартай, хариуцлагатай болж ирсэн учраас энэ харилцаа, харьцаа цаашдаа бас өөрчлөгднө байх гэж найдаж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулах уу. Сангийн яам хариулна. 9 номер.

С.Тулга: Сангийн яам Тулгаа Хосбаяр гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Эх үүсвэр нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж байгаа болохоор Азийн хөгжлийн банкны худалдан авах дүрмийн дагуу явагдана. Тэр бол тендер нь дандаа нээлттэй зарлагддаг. Тэгэхээр дотоодын хувийн хэвшил энэ ажил дээр оролцох бүрэн боломжтой.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Сангийн яамнаас асууя. Энэ 2024 оны жишээлбэл улсын төсөв дээр тавигдсан сургууль, цэцэрлэг, эмнэлэг, энэ барилга байгууламж барих, санхүүжүүлэх дүнгийн гүйцэтгэл нь ер нь хэдэн хувьтай гарсан юм бэ. Мэдээж нөгөө бид нар чинь 2024 оныхоо төсвийн гүйцэтгэл гарчихсан байгаа шүү дээ. Энийг хэлж өгөөч. Тэгээд бас магадгүй 1 барилга барих гээд тендерт шалгарсан компани ажлаа санхүүжилтийг нь 3 жилд хуваагаад тавьчихсан байхад эхний жилд нь өөрсдийн хөрөнгө, нөөц бололцоогоо дайчлаад, банкнаас зээл аваад ажлаа хурдан шуурхай дуусгачихсан байвал яах вэ. Тэр компани нь компанидаа ч ашигтай, улсад ч хэрэгтэй байна шүү дээ. Гэтэл тэр дараагийн 2 жилд олгох санхүүжилтийг нь нааш нь татаж олгох ч гэдэг юм уу, эсвэл ер нь тийм компаниудад тэр тодорхой хэмжээний хүүгийн дэмжлэг үзүүлэх ч гэдэг юм уу ийм бодлогын асуудал яригдах уу. Ер нь төрийн худалдан авахын хуульд өөрчлөлт оруулж ийм .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд асуултад хариулъя.

Б.Жавхлан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. 2024 оны гүйцэтгэлийг хэлчхээрэй. Тэр сүүлийн хэсэг дээр нь би нэмэлт мэдээлэл өгье. Тийм боломжгүй л дээ. Анх яг тендертээ ялаад, захиалагч яамтайгаа төсвийн ерөнхийлөн захирагчтайгаа ямар гэрээ хийсэн, тэр гэрээнийхээ дагуу л санхүүжилтээ хийх тэр үүрэгтэй. Тэр зээл аваад, санхүүгийнхээ ямар зохицуулалт, менежментээ хийнэ тэр бол хувийн хэвшлийн асуудал. Тэр дээр хүүгийн зохицуулалт гэж тийм зүйл ерөөсөө огт байхгүй шүү.

Г.Тэмүүлэн: 2 номер Дэлгэржаргал асуултад хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. 2024 оны гүйцэтгэл бол нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжих дүн талдаа бол 3,8 их наяд байсан. 12 сарын 31-ээр төсвийн жил дуусахад 3 их наяд 93 тэрбумыг санхүүжүүлсэн буюу гүйцэтгэл 80,6 хувьтай гарсан.

2024 оны хувьд онцлог нь бол нөгөө 2023 онд бид нар шинэ хөрөнгө оруулалт тавилгүйгээр өмнөх онуудаа дуусгах зарчим баримтлаад, буцаад 2024 онд шинэ хөрөнгө оруулалтуудыг нэлээн их төлөвлөсөн. Нийт хэрэгжсэн төслийн 712 нь бол шинэ хөрөнгө оруулалтууд байсан. Тэгэхээр 80,6 хувьтай гарсан.

Азийн хөгжлийн банкны түрүүний таны асуусан энэ төслүүд дээр хугацаа 5 жил байгаа ч гэсэн Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмаар явдаг. Дээрээс нь бид нар энийг хурдан шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээнд бэлтгэл ажил дээр бол цаг хугацаа алдахгүйн тулд одоо эдийн засгийн хүндрэлийг даван туулах гээд төсөл нь өөрөө хэрэгжээд явж байгаа. Яг энэ төсөл дээр сургууль, цэцэрлэг бас баригдаад явж байгаа. Үүний үргэлжлэл болоод энэ төслийн нэгж нь өөрөө цаашаа яг энэ худалдан авалтаа хийгээд явахаар байгаа. Тэгэхээр гадаад зээлийн ашиглалтын хувьд Сангийн сайдын багц дээр багц дүнгээр батлагддаг. Гүйцэтгэлд нь үндэслээд санхүүжүүлдэг учраас хурдан гүйцэтгээд, төслүүд нь дууссан тохиолдолд санхүүжилтийг нь түүнд нь уялдуулаад олгоод явах бүрэн боломжтой байгаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн болсон уу. Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Та бүхний энэ өдрийн амар амгалан айлтгая. Энэ төслийг ерөнхийдөө бол дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ хамгийн хэрэгцээтэй салбар эрүүл мэнд, боловсролын салбар, тэгээд онцгой байдлын салбарт хэрэгжиж байна. Ялангуяа бид нар энэ аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, эрчимжүүлэх энэ төсөл бас Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих гэж байгаад бас баяртай байна.

Энэ дээр харин асуух зүйлүүд байна. Салбарын яам энэ аймгийн 17 нэгдсэн эмнэлгүүдэд яаралтай тусламж, үйлчилгээ, эмчилгээний тасгийг сайжруулна гэсэн байна. Энэ 17 байршилаа сонгочихсон юм уу. Хөдөөгийн нэгдсэн 6 эмнэлэг гэж байна. Энэ бүсийн бодлоготой хэр уялдсан байгаа вэ. Тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин авна гэж байна. Энэ түргэн тусламжийн автомашины улсын стандарт нь батлагдсан уу. Мөн энэ хавдар, эрт илрүүлэг, эрчимт эмчилгээний тасгуудыг бол сайжруулна гэж байна. Энэ бол орон нутгийн эмнэлгүүдэд сайжруулна гэж ойлгож байгаа зөв үү.

Мөн сая Наранбаяр сайд хэлж байна. Сургууль, цэцэрлэгүүдийг 41 байршилд хэрэгжүүлэхээр нэмж шинээр барихаар бол яригдаж байгаа. Энэ дээр бас ажлын хэсэгтэй төсөлтэй хамтарч ажиллаж, байршлыг эцэслэн тогтоогдсон гэж ойлгож болох уу. Эсвэл бас өөрчлөлт орж болох уу. Анги дүүргэлт, хүртээмж, хүн амын хөгжлийн бодлого, энийг дахин оновчтой хийх боломж байгаа юу гэсэн 2 асуулт байна.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд Энхнасан гишүүний асуултад хариулья.

Ж.Чинбүрэн: Энхнасан гишүүний асуултад хариулья. Ер нь бол 17 аймгийн нэр орсон боловч энэ бол 21 аймагт хэрэгжих хөтөлбөр. Яагаад 17 аймаг орсон бэ гэхээр бусад жишээлбэл Дархан, Увс, Ховд, Эрдэнэтэд сая Увс Ховдод 6-8 сая долларын хүрээнд эмнэлгийн өргөтгөлүүд нь хийгдчихсэн. Дархан хотод бол Европын сэргээн босголтын банкаар эмнэлэг баригдаж байгаа гээд аль болохоор давхцуулахгүй, илүү оновчтой байх зорилгоор ингэж орсон. Тэгэхээр 17 гэдэг шалтгаан тэр. Уг төсөл бол бүгдээрээ бүх аймгуудад хэрэгжинэ. Жишээлэх юм бол Увс, Ховдод шинэ эмнэлэг барьсан ч гэсэн тэр дотор эрчимт эмчилгээ, яаралтай

тусlamж сайжруулах тоног төхөөрөмж, хүний нөөцийг бэлтгэх, мөн өмнө нь 170 гаруй сумуудад түргэнii машинтай болгосон. Тэгвэл тэдгээрийг үлдсэн сумуудад нь гүйцээх, аймгуудад дутуу машинуудыг нь гүйцээж олгох, тэгээд түргэн тусlamжийн машин нь бас өөрөө байнгын интернет холбоотой, камераар дамжуулан хүнээ тээвэрлэж байхдаа зөвлөгөө авч байдаг. Тэгээд очих гэж байгаа эмнэлэг нь хүлээж авах гэж байгаа газар нь ямар тусlamж энэ хүнд өгөх вэ гэдгээ бэлдээд байж байх. Жишээлбэл, зүрхний шигдээс болчихсон байгаа бол шууд ангиографи хийхэд бэлэн байж байх ч гэдэг юм уу гэх мэтчилэнгээр ингээд Монгол Улс даяар бүх аймгуудад эрчимт эмчилгээг сайжруульяа. Түргэн тусlamжийг түргэн хүрдэг болгоё. Яаралтай тусlamжийн төрөлжсөн мэргэжил жишээлбэл харвалт, шигдээс, тархины харвалт байна шүү дээ. Цус харвасан тохиолдолд шууд хагалгаа хийчих боломжтой байх. Ангиографтай байх, мөн хагарах гэж байгаа цүлхэнийг хамгаалах энэ тэр олон эмчилгээний аргууд. Дээрээс нь бас нярай хүүхдүүдийн эрчимт үйлчилгээ бас орж байгаа шүү. Тэгээд ийм байдлаар бид нар хөгжүүлэх гэж байгаа юм.

Зүгээр бид нарын гол зорьж байгаа зорилго бол ер нь энэ 5 жилийн хугацаанд аварч болох нас баралтыг 26 хувиар бууруулах .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Наранбаяр сайд асуултад хариульяа.

П.Наранбаяр: Баярлалаа. Энхнасан гишүүний асуултад хариульяа. Тэгэхээр энэ 41 байршил маань бол түрүүн миний хэлсэнчлэн яг газар зүйн мэдээллийн системийг ашиглаад, хүн амын нягтшил, бүлэг дүүргэлт, бүхий л тооцох ёстой зүйлүүдээр эрэмбэлсэн байгаа. Гэхдээ энэ ерөнхий хэлэлцээр байгуулагдсаны дараа яг нарийвчилж тухайн сургууль, сургууль тус бүрээр нь, цэцэрлэг, цэцэрлэг тус бүрээр нь бас ийм гэрээ хэлцэл байгуулагдаж явна. Тэр үедээ үнэхээрийн хэрэгцээ шаардлага нь өндөр бэлэн газартай, шаардлагатай гэж үзсэн юм байвал өөрчлөлт орох боломж бас байгаа гэж харж байгаа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүн нэмж тодруульяа.

Л.Энхнасан: Тэгэхлээр байршил нь өөрчлөхгүй, зөвхөн нөхцөл дээр нь өөрчлөлт орох боломжтой гэж ойлгох уу.

Г.Тэмүүлэн: Наранбаяр сайд нэмж хариульяа.

П.Наранбаяр: Тийм. Ер нь бол байршууд их нарийн бодож орсон байгаа. Зүгээр нөхцөлүүд гэвэл жишээлбэл 960-тай байвал 640 болох ч юм уу. Суудлын тоо иймэрхүү зүйлүүд бол яригдах байх. Түүний зэрэгцээ бас энэхүү төсөл дээр дэд бүтцийг нь бүрдүүлэхэд тодорхой хэмжээнд бас дэмжлэг үзүүлэх ийм өөр хандивлагч байгууллагууд боломжтой гэдгээ илэрхийлсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалттай юу. Хаанаас хариулах вэ. Энхнасан гишүүн нэмж тодруульяа.

Л.Энхнасан: 17 аймаг дээрээ бас эхлээд яг энэ, энэ аймгуудын эмнэлгийг түрүүлж барина. Тэгээд дараа нь бүсчилсэн хөгжилтэйгөө холбоотой дараа дараагийн аймгуудыг барина гэсэн тийм ямар тооцоолол байна. Яагаад би энийг асууж байна вэ гэвэл түргэн тусlamж жишээлбэл Өмнөговиос хот руу явж байгаа хүн тээвэртэй холбоотой ослууд нэлээн их гардаг. Өмнөговь руу буцаж явж хүн

эмчлүүлнэ гэж байхгүй. Дундговьд түрүүлж барих, Хэнтийд барих гэх юм уу. Говь-Алтайд гэсэн энэ эмнэлгүүдээ түрүүлж барина гэсэн тийм бодлого байна уу.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд асуултад хариульяа. Тэгэхээр бид нөхцөл байдлын үнэлгээ хийсэн. Жишээлэх юм бол яаралтай тусламж хаана дутаад, юу нь дутаад байгаа гэдэг аймаг болгон дээр тусдаа гарсан. Тэгэхээр аймаг болгон дээр зарим газар нь жишээлбэл яаралтай тасгийн өргөтгөлийг барих, зарим газар нь бүр эрчимт эмчилгээ, хагалгааны хэсэг шинэчлэх шаардлагатай, зарим хэсэг нь бол хүзүүвчээр холбох ч гэдэг юм уу аймаг бүр дээр өөр өөр. Бүгд зэрэг эхэлнэ. Тэгэхээр аль нэгийг нь түрүүлээд хийх биш. Ерөөсөө л зэрэг хаана юу дутуу байгаа яг л бүгдийг нь нэг стандартад аваачаад, бүгд адилхан. Нэг ёсондоо Улаанбаатар луу яаралтай тусламжийн шалтгаанаар Улаанбаатар луу ирдэггүй болгох л том зорилго тавиад байгаа. Тэгэхээр бүх аймгууд. Мөн зарим сумууд орсон байгаа. Тийм ээ. Тэр сумуудын шалгуур нь ерөөсөө л замын огтлолцол, зам осол их гардаг газар ч байдаг юм уу, хүн амын суурьшил ч гэдэг юм уу гэх мэтчилний нөхцөлүүдээр шалгаруулсан байгаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу. Номин гишүүн асуулт асууяа.

Ч.Номин: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ер нь бол энэ хэлэлцээрийг дэмжиж байгаа. Мэдээж боловсрол, эрүүл мэнд, онцгой байдал гээд чухал салбаруудыг хөрөнгө оруулалтад зориулах гэж байгаа зээл бөгөөд 2 дахь нь бас хүүгийн зардал бол багатай учраас дэмжиж байгаа. Гэхдээ уг нь бол айлаар бодох юм бол бид нар яаж байна вэ гэхээр яваад хүүхдээ эмнэлэгт үзүүлэх, эсвэл хүүхдээ сургуульд сургах мөнгөө зээлээр аваад, өөрсдөө байгаа мөнгөө болохоор өөр зүйлд зарцуулаад байгаа ийм зүйл болж байгаа. Уг нь бид нар ийм бага хүйтэй, хүүгийн зардал багатай зээлийг эдийн засгийн өгөөжтэй зүйл рүү чиглүүлэх нь чухал. Тэгээд эндээсээ буцаад бид нар төсвөөсөө Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхэд нийцэх зүйлүүдээ хийж явах нь зүйтэй гэж бодож байгаа. Гэхдээ энэ дээр бол одоо дэмжинэ гэсэн байр суурьтай байгаа.

Тэгээд надад 3 асуулт байна. 1 дүгээрт болохоор энэ батлагдсан зээлийн хөрөнгө ашиглалтын хувь хэдэн хувьтай байгаа бол. Ашиглагдаагүй зээлийнхээ зардал буюу энэ хөрөнгө нөөцөлсний зардалдаа нийтдээ яг улсын хэмжээнд хэдэн төгрөг төсөвлөөд, зарагдаад явж байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

2 дугаарт болохоор төсөв дээр тавигдахдаа болохоор гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх 2026 оны төслөөр болохоор 6 төсөл байгаа юм. Тэгээд эндээс энэ онцгой байдалтай холбогдолтой 1 заалтыг нь хасаад, оронд нь хөдөө аж ахуйн салбар дээр хийгдэх гэж байгаа Дарханд хийгдэх гэж байгаа хөрөнгө оруулалтыг оруулж ирсэн байна л даа. Энэ ямар үндэслэлээр тэр гамшгаас сэргийлэх хэрэгжүүлэх гэж байсан 30 саяынхаа төслийг хасаад, оронд нь энэ коллеж буюу политехникийн коллежийг оруулж ирж байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

3 дахь асуулт болохоор энэ төслийн нэгж яаж байгуулагдах вэ гэдэг асуулт байна. Яагаад би энийг асууж байгаа вэ гэхээр би бас сайд байх үед энэ Эй Ди Би-ээс авч байсан тогтвортой аялал жуулчлалын төслийг хүлээж авч байсан. Тэгээд энэ дээр бол төслийн нэгж нь маш муу ажилладаг. Маш олон илүү дутуу зардлыг менежментийн фий, эсвэл сургалт гэдэг байдлаар гаргаж авдаг. Тэгээд чадваргүй хүмүүсийн төслийн нэгжууд дээр бий болдог ийм асуудлууд гардаг юм байна гэдэг нь харагдсан. Тэгэхээр энэ төсөл төслийн нэгж нь яаж хийж явах гэж байгаа вэ. Төслийн нэгжийг яаж хянаж явах гэж байгаа вэ гэдэг ийм 3 асуулт байна.

Г.Тэмүүлэн: Номин гишүүний асуултад хариульяа. Дэлгэржаргал 2 номер.

Ж.Дэлгэржаргал: Номин гишүүний асуултад хариульяа. Дэлгэржаргал Сангийн яам. Төслийн нэгж дээр яг таны хэлсний дагуу бид нар ер нь судалгаа хийгээд, энэ гадаад зээлийн хэрэгжилт, үр ашиг бас хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд төслийн нэгжийн зохион байгуулалт, тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж яам үзсэн. Энэ хүрээндээ бид нар өнгөрсөн хавар яг доноруудтайгаа уулзаад, мэдээлэл судалгаанууд хийгдээд, 7 сард Засгийн газарт танилцуулаад, тогтоол гаргасан. Энэ нь бол нэгдсэн төслийн нэгж буюу төсөл болгон дээр төслийн нэгж байх ер нь бол шаардлагагүй. Ер нь бол яг тухайн салбар дээр, ялангуяа олон төсөлтэй салбарууд дээр нэгдсэн 1 төслийн нэгжтэй байгаад, илүү тогтвортойгоор тухайн төслүүдээ хэрэгжүүлж явах, нөгөө талд нь төслийн нэгжийг яг яамныхаа нөгөө бүтцэд 1 байх, өөрөөр хэлбэл яг яамны бодлого чиглэлтэй нэгдсэн бодлогоор ажиллах тэр төслүүдийг яг гэрээ хэлэлцээр байгуулагдсан хугацаанд нь ашиглалтад оруулах ийм чиглэлүүд хүргүүлсэн. Тэгээд тогтоолын хүрээнд одоогоор улсын хэмжээнд 46 төслийн нэгжтэй 474 хүн ажиллаж байгаа бол нэгдсэн төслийн нэгжийн зохион байгуулалтад орсноор 203 буюу нийтдээ 270 хэдэн хүнээр орон тоог багасгаж, зохион байгуулалт, өөрчлөлт хийсэн. Өнгөрсөн 7 хоногт тогтоолыг үндэслээд Сангийн сайдын тушаалаар түр журам буюу яг энэ шилжилтийн тогтолцооны өөрчлөлтийг хийх түр журам батлагдсан. Тэгэхээр энэ төслүүдийн хувьд шинээр төслийн нэгж бол байгуулахгүй. Одоо байгаа яг нэгдсэн төслийн нэгжийн зохион байгуулалтад ороод, урсгал зардлаа хэмнээд, яг тэр хүмүүс дээрээ зохион байгуулалтаа хэрэгжүүлээд явна. Цаашдаа бол яг шинэ гэрээ хэлэлцээр байгуулагдах болгонд төслийн нэгж байгуулахгүйгээр тухайн салбар дахь нэгдсэн төслийн нэгж өөрөө гадаад зээлийн төслүүдээ нэгдсэн удирдлагаар хангаж авч явах ийм зохион байгуулалтыг хийсэн байгаа. Энэ зарчмаар хэрэгжээд явна.

Г.Тэмүүлэн: Бусад асуултууд дээр хариулах вэ. Хэн хариулах вэ. 9 номер.

С.Тулга: Тулгаа Сангийн яам. Тэр нөгөө хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан болон коммитмент фий талаар мэдээлэл өгье. Энэ төлбөрийг бол бид нар энгийн эх үүсвэртэй зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл дээр төлдөг. 2023 онд бол бид энэ төлбөрт 13,1 тэрбум, 2024 онд 39,4 тэрбум, 2025 онд 51,3 тэрбум төгрөг, 2026 онд 59,6 тэрбум төгрөг, 2027 онд 47,4 тэрбум төгрөг болж буурахаар, 2028 онд 46,7 тэрбум төгрөг ч болж буурахаар ийм төсөөлөлтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Номин гишүүн нэмж тодруулъяа.

Ч.Номин: Дутуу хариулчихлаа. Яг хөрөнгө ашиглалт нь хэд байгаа вэ гэдгийг, зээлийн ашиглалт нь хэд байгаа гэдгээ асуумаар байна. Би энэ төслийн нэгжтэй бол санал эрс эсрэг байна. Яадаг вэ гэхээр сүүлдээ энэ яамнууд чинь бүгдээрээ барилгын яам шиг болдог. Ийм төслийн нэгж удирдах чадваргүй бүтэц дээр аваачиж нэмж оруулж ирээд, тэгээд бүр нөгөө төсөл нь удаашраад, тэрнээсээ болоод зээлийн эргэн төлөлт чинь удаашрах, дахиад дээрээс нь зээлийн хөрөнгөөр оруулж байгаа хөрөнгө оруулалт чинь удаашрах, өртөг нэмэгдэх гээд зүйлүүд гарч ирдэг. Энийг бол би бас Засгийн газрын харж үзэх ёстой зүйл гэж бодож байна. Ерөөсөө яамнууд бол энэ төслийн нэгжийг удирдаж авч яваад, үр ашигтайгаар гаргаж ирж чадна гэж үзэхгүй байна. Харин ч бүр асуудал болохоор шийдвэр гарсан байна гэж харж байна. Тэгээд би нөгөө түрүүний асуусан асуулт буюу яагаад хөдөө аж ахуйн салбар луу шилжсэн бэ. Төсөв дээр тавьсан 6 төслөөсөө өөр болсон байна гэдгийг асуугаад, 2 дугаарт түрүүний хөрөнгийн зарцуулалт ч хэр хэмжээтэй байгаа гэдгээ нэмээд авчихъяа.

Г.Тэмүүлэн: Асуултад хариульяа. Хэн хариулах вэ. Дэлгэржаргал 2 номер.

Ж.Дэлгэржаргал: Төслийн нэгжүүд дээр бол яах вэ, бид нар олон улсын байгууллагуудтайгаа яриад бид нарын гаргасан тооцооллоор бол илүү сайжирна гэж үзэж байгаа. Одоо улсын хэмжээнд 46 төслийн нэгжийг бид нар 17 болгож бууруулаад, дээрээс нь яг энэ төслийн нэгжийн ажилтнууд 1 жилээр хөлсөөр ажиллах гэрээ хийж ингэж ажилладаг байсныг илүү тогтвортой, дунд хугацаанд 3 жилээр гэрээ байгуулах ийм боломжуудыг нь олгоод, мөн дээрээс нь яам өөрөө яг хэрэгжүүлэгч байгууллага буюу гэрээ хэлэлцээрийн хүрээнд тухайн яам нь яг тэр хэрэгжүүлэгч байгууллагаар явдаг учраас яамны үүрэг хариуцлагыг илүү оролцуулж, нягт ажиллах ийм зохион байгуулалтуудыг хийж байгаа.

Яг гадаад зээлийн ашиглалт дээр бол бид нар энэ дээр анхнаасаа яг төлөвлөсөн буюу онцгой дээр байсан 30 сая ам.долларыг боловсрол руу авсан ч юм уу, хөдөө аж ахуй руу авсан тийм өөрчлөлт байхгүй. Яг анхны хэлэлцээр, түүнийхээ дагуу бид нар 2026 онд гадаад зээлийн ашиглалт дээрээ боловсролын 130 дээр хөдөө аж ахуйн МСҮТ, мэргэжил сургалтын 20 гээд 150-ийг боловсролын салбар дээр гээд яг анх төлөвлөсөн дүнгээрээ л явж байгаа. Өөрчилсөн зүйл болон шилжүүлсэн зүйл бол байхгүй байгаа.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн асуулт асууяа.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхээр Азийн хөгжлийн банкнаас авах энэ зээлийн ерөнхий хэлэлцээрийг дэмжиж байгаа. Их Хурлын гишүүдээс гаргаж байгаа санал байгаа. Гол нь тэр бүтээн байгуулалт явагдах эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн аймгууд, дүүргүүд сонголт шалгуур тавихдаа энэ үндэслэлээ бас их тодорхой болгож, мөн гишүүдийн гаргаж байгаа саналын дагуу бас дахиж эрэмбэлж ажиллах нь зүйтэй байх. Зүгээр ерөнхий хэлэлцээрээ бол Азийн хөгжлийн банкны талтайгаа батлаад явах нь зүйтэй гэж үзэж байна. Тэгэхээр энийг бас ажлын хэсэг, Сангийн яам маань бас онцгой анхаараарай. Өөрөөр хэлбэл зөвхөн тэнд сууж байгаа хэдэн мэргэжилтэн, аль эсвэл ганц сайд мэдээд энэ асуудлыг бас шийдэж болохгүй гэдэг дээр Их Хурлын гишүүдтэй бас санал нэг байгаа. Тэгэхээр энэ хэлэлцээрийг бол дэмжиж байгаа.

Тэгээд цаашлаад ер энэ гадаад зээлээр хэрэгжиж байгаа төслүүд дээр бас онцгой анхаарал хандуулж байна. Ялангуяа цаг үетэй холбоотойгоор ОХУ-ын нөхцөл байдал, энэ зэвсэгт мөргөлдөөн, дайны улмаас Монгол Улсад бас дам нөлөө буюу түлш, газрын тосны бүтээгдэхүүний хомсдол үүсэх ийм том эрсдэл бол ойрын үед байгаа. Үүнтэй холбоотойгоор бол Энэтхэгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Газрын тос байгуулах үйлдвэрлэл, энэ дээр ямар нэгэн байдлаар 2026 оны төсөв дээр та бүхэн төлөвлөгөөний дагуу энэ төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийг бүрэн шийдэж чадсан уу. 2026 оны төсөвт ямар хэмжээтэй суусан. Өөрөөр хэлбэл энэ төсөл цаашид хэрэгжиж явахад Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтолц, дээр нь Монгол Улсын үйлдвэрлэлийн бүтцэд ийм өөрчлөлт орох ийм том төсөл хэрэгжихэд ямар нэгэн байдлаар зээлийн хүндрэл гарахаар юм байгаа юу. Энэ дээр бас хариулт авмаар байна.

Тэгээд дараа нь санал хэлмээр байна.

Г.Тэмүүлэн: Асуултад хариульяа. 2 номер.

Ж.Дэлгэржаргал: Тулга гишүүний асуултад хариульяа. Сангийн яам Дэлгэржаргал. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол бүгд Энэтхэг улсын Эксим банкны нэн хөнгөлөлттэй зээл байгаа. Гэрээ хэлэлцээрийн хугацаа бол 2028 он гэхэд дуусах хугацаатай буюу 2028 он гэхэд зээлийн ашиглалтыг ашиглаад, үйлдвэрээ ашиглалтад оруулсан байх хугацаатай. Одоогийн байдлаар сүүлд нэмэлт хэлэлцээр байгуулагдсан. И Пи Си 4 хэлэлцээрийн хүрээнд гэрээнийхээ дагуу урьдчилгаа төлбөрийг бол бид нар өнгөрсөн 7 хоногт олгосон байгаа. Ирэх оны гадаад зээлийн ашиглалт төсвийн төсөл дээр нийтдээ 1,5 их наяд байгаа. Энэ дээр бас газрын тос дээр 210 тэрбум төгрөгийн ашиглалтыг бид нар хуваарилчихсан явж байгаа. Хэдийгээр одоо яг гадаад зээл дээр яг энэ дүнгээрээ явах юм бол бид нар 2028 он гэхэд бол газрын тосыг бүрэн ашиглаж амжихгүй. Өөрөөр хэлбэл одоо ашиглалт бол нэлээн өндөр шаардлагатай. Одоо яг 1,5 гэдэг энэ түвшнээрээ явах юм бол 2028 он хүртэл зөвхөн газрын тос дээр л бид нар ашиглалт гарах ийм тооцоолол байгаа. Тэгэхээр нийт үлдэгдэл нь өөрөө 4,8 их наядаас ирэх жил бид нар 210-ыг л ашиглах ийм тооцоололтой. Тэгэхээр гадаад зээлийн ашиглалт дээр бол зайлшгүй нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага бол маш өндөр байгаа.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн нэмж тодруулъяа.

Б.Тулга: Тэгэхээр 3 жил үлдсэн 1 дүгээрт. З жилээс ч өмнө хэрэгцээ шаардлага бол маш өндөр болж байна. Бид нар ОХУ-аас олон улсаас бол 1 тэрбум амдолларын худалдан авалтыг жил болгон хийж байгаа. Одоо нөгөө бүтээгдэхүүн маань байхгүй болох гээд байдаг. ОХУ-д өнөөдрийн байдлаар нефть боловсруулах үйлдвэрийнхээ хүчин чадлын 40 хувийг алдчихсан байгаад байдаг. Тэгээд энэ өвөл, ирэх хавар энэ хомсдол юу юугүй тулж ирэх гээд байдаг. Тэгтэл бид нар зээлийн ашиглалт дээрээ энэ газрын тосны үйлдвэрийн зээлийг нэмж өгөхгүй юм уу. Сангийн сайдаас асуумаар байна. Одоо төсөв ярьж байгаа үед энийг нэмэхгүй бол төсөв батлагдчих юм бол хэдүүлээ энэ зээлийн ашиглалтыг нэмэгдүүлж чадахгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас нэмэгдүүлэх Засгийн газрын зүгээс ямар санал оруулж байна. 2028 ондоо саяын өгсөн мэдээллээр бол 2028 ондоо ч бүрэн дуусгаж, ашиглаж чадахгүй ийм нөхцөл рүү орчихсон байдаг. Гэтэл хэрэгцээ маань үүнээс ч илүү их гарчхаад байдаг. Сангийн яам энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ.

Г.Тэмүүлэн: Асуултад хариульяа Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тулга гишүүний асуултад хариульяа. Тэр том төслүүдийг бол бид арай жоохон тусад нь хараад, шалгуурыг нь өөрөөр тавиад, Их Хурал дээр тэр шалгуур, босго давсан ийм төслүүдийг төсвийн алдагдалд тооцмооргүй байгаа юм. Тэгээд гол нь өөрөө өөрийгөө төлөөд явчихаар эргээд төсөв дээр хүндрэлээ авчирчихгүй тэр төслүүд тийм шаардлагуудаа тавиад, тэгээд болохгүй гэвэл болохгүй л биз. Хэрвээ болж байгаа шалгууруудыг нь давж байгаа тийм босгыг нь давж байвал алдагдалдаа оруулахгүйгээр харин нийт Засгийн газрын өрөндөө бол мэдээж таазандаа тооцолгүй яах вэ. Тэр эрсдэлээ бол менеж хийгээд явна. Ийм байдлаар томоохон төслүүдээ бусад төслүүд дээрээ пауз авах ийм бас орон зайг нь гаргаж, тэр төслүүдээ бас яаралтай дуусгаад, Монголд Улсад өгөөж өгөх тэр ажлыг нь бушуухан эхлүүлэх. Ялангуяа таны хэлж байгаа тэр нефть боловсруулах үйлдвэр хэрвээ .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Минут нэмж өгье Жавхлан сайдад.

Б.Жавхлан: Хэрвээ 2028 онд ашиглалтад оруулах юм бол уг нь жилдээ 1,5-2 тэрбум долларын гадагшлах урсгалыг дотооддоо авч үлдээд байх л ийм л боломжууд гараад байх юм л даа.

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн нэмж тодруулъя.

Б.Тулга: Тэгэхлээр Их Хурал дээр шийдвэр гарах ёстай гэж та хэлж байна гэж ойлгож болох уу. Өөрөөр хэлбэл Засгийн газраас ямар нэгэн санал бэлэн байгаа юу. Хэрвээ Их Хурал дээр шийдвэр гарах ёстай бол яг өдийд төсвийг ярьж байх үед хэдүүлээ ярих ёстай юм болов уу гэж бодож байна. Энэ том бүтээн байгуулалт бол би түрүүн хэлсэн. Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг бий болгох, нефтийн газрын тосны бүтээгдэхүүний хараат байдлаас гарах маш чухал ач холбогдолтой. Тийм учраас эндээс шаардлагатай бол бид нар бас ажлын хэсэг байгуулаад, энэ дээр төсвийн хүрээнд ажиллахад бэлэн байна гэдгээ бас хэлмээр байна. Тэгэхээр Засгийн газраас энэ дээр техникийн мэргэжилтний туслалцаа үзүүлж бас ажиллавал сайн байна. Ер нь энэ газрын тосны үйлдвэрийг бас зарим улс төрчид, манай Их Хурлын гишүүд дотроос эсэргүүцэж зогсоох, гацаах ийм хандлагууд бас ажиглагдаад байгаа. Ялангуяа мэдэгдэл хийж байгаа зарим гишүүд. Тэгэхээр энийг бас манай Улсын Их Хурлын гишүүд онцгой анхаарч явахгүй бол Монгол Улс маань өөрсдөө тэр чиг үүгээрээ ОХУ-ын нөхцөл байдлаас хамаараад хүнд байдалд орох ийм нөхцөл байна шүү гэдгийг бас дахин энд .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Тулга гишүүн үг хэлчихлээ. Энэ зээлийн хэлэлцээртэй холбогдуулаад би бас тодруулж, лавлаж асуух хэд хэдэн зүйлүүд байна. Өнгөрсөн 7 хоногт манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор зээлийн хэлэлцээртэй холбоотой эрх ашигтай холбоотой, хүндрэлтэй холбоотой мэдээллүүдийг сонссон. Энэ дундаа зүгээр нэг талдаа асуудал бол өөрөө улсын төсвийн хөрөнгө оруулалт дээрээс бид нар хөрөнгө оруулалтыг оновчтой бөгөөд үр ашигтай зүйлд бол зарцуулах ёстай асуудал байгаа. Мэдээж өнөөдрийн зээлийн хэлэлцээрээр бол боловсрол, эрүүл мэнд, онцгойтой холбоотой 3 асуудал орж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр нэг талдаа зарчим талаасаа бол маргаад байх зүйл байхгүй байгаа.

2026 оны улсын төсөв дээр үндсэндээ хөрөнгө оруулалт 8,9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт байгаа. Улсын төсвөөс өөрөө үндсэндээ 3,3 их наяд, гадаад зээл тусламжаас 1,5 их наяд, орон нутгаас 3,9 их наяд байгаад байгаа. Тэгээд үндсэндээ 8,9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг 1 жилийн улсын төсөв дээр тавина гэдэг бол өөрөө бас асар том дүн. Тэгэхээр зүгээр бид нар түүхээ эргээд санаад 2015 онд бид нар 1,4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг л шийддэг байсан. Тэгэхээр энэ бол нэг талдаа улсын төсөв дээр бид нарт асар том боломж бололцоо бий болж байна гэдэг зүйл харагдаад байгаа юм.

Гэтэл нөгөө талдаа бид нар яг үндсэндээ юу гэдэг юм энэ хөрөнгө оруулалтуудаар бодлогын шинжтэй асуудлуудаа шийдэж чадаж байна уу гэдэг асуудал байгаа. Бодлогын шинжтэй асуудлуудаа шийдэж чадаж байна уу. Ингээд үзэхээр бараг үгүй болчоод байгаа юм. Боловсролын салбар дээр асуудал байна. Эрүүл мэндийн салбар дээр асуудал байна. Онцгой ч гэдэг юм уу, нэн яаралтай хүний хөгжилтэй холбоотой асуудлууд дээр ч бас асуудлууд байна. Өнөөдөр жишээ нь бид нар буцаагаад аваад үзэх юм бол Боловсролын сайдын хэлж байгаа ирэх жил боловсролын хөгжлийг дэмжих жил болгож зарлаж байгаа. Ирэх 2028 он гэхэд бараг 100 орчим сургууль, цэцэрлэг хэрэгтэй байна гэдэг асуудлууд байдаг.

Гэтэл өнөөдөр бид нар энэ улсын төсөв дээрээсээ үндсэндээ 40 орчим сургууль, цэцэрлэгийн асуудлуудыг шийдэж байна. Тэгээд бусад сургууль, цэцэрлэгийн асуудлууд хүндрэлтэй байна. Тэгэхээр энэ дээр одоо бид нар ер нь яг үр ашиг, эрэмбэ дарааллын асуудлууд орхигдоод байгаа юм биш үү. Өнөөдөр орж ирж байгаа энэ 475 сая долларын зээлтэй холбоотой асуудал маань ч гэсэн яг эрх ашгийн эрэмбээрээ шийдэж чадаж байгаа юм уу л гэдэг асуудал байхгүй юу. Одоо 225 сая доллар нь бол эрүүл мэндийн салбар дээр гээд энэ 17 нэгдсэн эмнэлэг, 6 хөдөөгийн эмнэлэг байгаа. 130 сая нь бол 32 сургууль, 9 цэцэрлэг дээр байгаад байгаа. Боловсролын салбар дээр. Цаана нь дахиад 20 сая бол ажиллах хүчинтэй холбоотой гэдэг юм уу, хөдөө аж ахуйн салбар дээр байгаа. 100 сая доллар нь гамшиг дээр байгаад байгаа. Тэгэхээр би зүгээр хэлэх гээд байгаа горимын санал бол үндсэндээ бид нар 2026 оныг Боловсролыг дэмжих жил гэж зарлаж байгаа бол нийт зээлийнхээ магадгүй 60-70 хувийг нь ч гэдэг юм уу энд зарцуулж болдоггүй юм уу. Эсвэл үндсэндээ бид нар 8,9 их наяд төгрөгийн улсын төсөв дээр хөрөнгө оруулалт байгаа бол болж өгвөл ядаж 20, 30 хувийг нь ийш нь зарцуулаад суурь асуудлуудаа шийдэж болдоггүй юм уу. Бид нар өнгөрсөн жил үндсэндээ 2024 оны улсын төсөв дээр чинь 1 ч хөрөнгө оруулалт тавигдаагүй шүү дээ. Сургууль, цэцэрлэгийн асуудлуудыг хөндөж тавиагүй. Бид нар энэ олон мега төслүүдийг төслүүдийг явуулна гээд үндсэндээ бүгд бүсээ чангалаа гээд тэвчсэн.

Зөвхөн нэг бүсийн жишгээр аваад үзэхэд Хангайн бүс дээр бид нар 4, 5 сургууль, цэцэрлэг, 4, 5 сургуулийн өргөтгөлийн асуудлууд нэн тэргүүнд хэрэгтэй байгаад байгаа. Бид нар эрэмбэлье гэвэл магадгүй өнөөдөр харьцангуй эрүүл мэндийн салбар гайгүй болчихсон гээд боловсролоо нэгд тавимаар байдаг Хангайн бүс дээр. Өвөрхангай аймгийн төв дээр, Архангай аймгийн төв дээр 2, 3 цэцэрлэг үндсэндээ ачааллаа дийлэхээ больчихсон, нэн шаардлагатай байгаад байдаг гэхээр би энэ асуудал нь өөрөө хуваарилалт нэг талдаа зөв үү. Боловсрол, эрүүл мэнд бол маргалдах юм байхгүй. Гэхдээ 130-ийг бид нар боловсрол дээр тавьчхаад боловсролын салбарын хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлээд ингээд болохгүй юм уу. Эсвэл бусад юу гэдэг юм зарим үр ашиггүй байж болох, эсвэл зарим өнгөрсөн жил эхлүүлсэн тэр мега төслүүдээ заримыг нь хойшлуулаад, царцаагаад, төсөвт ачаалалгүйгээр, тэр хувийн хэвшлийн түншлэлээр ч гэдэг юм уу шийдэх боломж байна уу л гэдэг асуудал яриад байгаа юм.

8,9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт гэдэг бол бас том дүн шүү. Энэ дээр та хэд маань бас ямар байр суурьтай байгаа юм бэ. Бид нар бол энэ дээр анхаарч үзэх, эрх ашгийн эрэмбээр боловсрол, эрүүл мэндээ 1 дүгээрт тавиад, энэ хоёрынхoo суурь асуудлуудын 1 бодлогын шинжтэй асуудлуудаа шахаад явчихвал яасан юм бэ л гэсэн ийм санал байгаа. Зөвхөн энэ зээл ч биш, нийт улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд дээр. Энэ дээр Сангийн сайд. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэмүүлэн даргатай санал нийлэхгүй байна. Сүүлийн жилүүдэд ер нь гадаад зээлийн ашиглалт, гадаад зээлийн бодлого, гадаад зээлийн салбарын хуваарилалт бол ер нь бол зөв чиглэл рүүгээ явж байгаа. Бид 20018 оноос эхлээд гадаад зээлийн хувьд Өрийн удирдлагын тухай хуульд Олон улсын валютын сангаас гэрийн даалгавар авч үлдсэний дагуу 3, 3 жилээр үндсэн чиглэлээ батлуулаад явдаг болсон байгаа. Үүний үр дүнд ч бид 12 жилийн дараа 12 жилийн өмнө хүрч байсан зээлжих зэрэглэлийнхээ тэр цэг дээр хүрч чадсан өнгөрсөн жил. Тэгэхээр манай гадаад зээлийн өр бодлогын хувьд том зургаараа бол бид нар зөв чиг хандлага руугаа явж байгаа.

Харин салбар хоорондын зохицуулалт, салбар хоорондын хуваарилалт дээр бид бүрэн цэгцээрсэн гэж хэлэхэд хэцүү. Тантай бол санал нийлж байна. Энэ жил сая 8 сард төсөв өргөн барихын өмнө бид анх удаа нэлээн өргөн сошиал платформоор олон нийтийн санал, асуулга авч, ер нь тэргүүлэх чиглэлийн салбар юу байх вэ гэдгийг харлаа. Тэгэхээр энэ удаа орж ирж байгаа энэ 3 зээлийн зориулалт маань бол яг энэ тэргүүлэх салбарууд дээр байгаа.

Гэхдээ салбарын маань яг бэлэн байдал, захиалагч яамны маань бэлэн байдал гэдэг бас их асуудал байна. Ингээд Азийн хөгжлийн банктай хэлэлцээр орохоор энийг л хамгийн түрүүнд нэхдэг. Танайх аль салбар чинь түлхүү аваад, богино хугацаанд хурдан шингээх чадвар нь аль нь байна: Бэлэн зураг төсөл, судалгаа, газар зүйн байрлалын хувьд гээд маш олон шалгуурууд тавьдаг. Тэгэхээр яах аргагүй энэ удаагийн дунд хугацааны хэлэлцээр дээр бол өмнө нь хэлэлцээр хийж байх шатад бол яг Эрүүл мэндийн яамны бэлэн байдал нь бол хамаагүй мундаг байсан. Одоо энэ 225 сая доллар 17 аймаг гэж байгаа бол энэ чинь сүүлийн бараг 4, 5 жилийн хугацаанд судалгаа нь хийгдчихсэн байсан. Мөн хэлэлцээрийн өмнөх шатууд нь бас явж байсан ийм зүйл. Ингээд одоо үлдэж байгаа орон зайн дээр нь 130 сая доллар дээр бид үндсэндээ 2026 оны төсвөө 1 сар, 2 сараас төлөвлөж эхлэхэд хойтон 2026 онд боловсролын жил болгоно гэдгийгээ зарлаж тодорхойлсон байдаг. Ингээд Азийн хөгжлийн банкны ерөнхий хэлэлцээр дотор үлдсэн 130 сая доллар дээрээ Боловсролын яамны бэлэн байдал хангасан тэр 41 төсөл буюу энэ дотор 32 сургууль, 9 цэцэрлэг гэсэн ийм байдлаар орж ирж байгаа. Гэхдээ л бас Боловсролын яам маань бэлэн байдал хангасан уу гэхээр энэ жил зээлд хүрэхгүйгээр яг бэлэн хэдэн төсөл байна гэхээр ерөөсөө 3 сургууль, 2 цэцэрлэг, 2 дотуур байр л гарч ирж байгаа юм. Газар нь бэлэн, зураг нь бэлэн гээд. Ингээд цаашаагаа нөгөө эрэмбэлэгдсэн 108 сургууль, 90 хэдэн цэцэрлэгээс маань бэлэн байдал хангасан нь байхгүй учраас яг ингээд дээрээсээ таслагдаад, зээл рүү орж ирж байгаа.

Ер нь бол яах вэ, энэ удаа орж ирж байгаа зээл нь энэ 2 салбар харагдаж байгаа боловч нийт зээлийн ашиглалтаа харах юм бол бид бусад өөр салбарууд дээр дэд бүтцийн салбарууд дээрээ нэлээн томоохон зээлийн ашиглалтын гэрээнүүд хүлээгдэж байна. Мөн өнгөрсөн хугацаанд ч гэсэн яг энэ дэд бүтцийн салбар маань өөрөө их томоохон зээлүүд шингээдэг учраас 1 төсөл гэхэд л Нефть боловсруулах үйлдвэрийн төсөл гэхэд л үндсэндээ бараг 2 тэрбум доллар хүрч байгаа ийм байх жишээтэй. Цаана нь эрчим хүчний салбар дээр мөн л ЦДАШ-ууд маш их том дүнгүүдтэй ийм зээлийн ашиглалтуудтай энэ бодлогын хүрээнд явж ирж байна.

Тэгээд цаашдаа ер нь бид нарын .../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд 1 минут.

Б.Жавхлан: Тэгэхээр цаашдаа ер нь гол тулгамдаж байгаа асуудал бол зээлийн ашиглалтаа бүртгэлийн хувьд олон улсын стандарт руу шилжүүлэх, энийг их зөв тооцож, тайлагнаж байх ийм ажил бидний өмнө байгаа.

Г.Тэмүүлэн: Өнгөрсөн онд бид нар нэг төсөв баталж байх үед ийм зүйл гарч байсан юм. Өнгөрсөн он чинь бол 2024 онд ерөөсөө улсын хэмжээнд 1 ч хөрөнгө оруулалт байхгүй гээд зогсож байсан. Тэгээд үндсэндээ 2023 он болон түүнээс өмнө ирсэн барилга бүтээн байгуулалтын ажлууд байгаад байгаа юм. Дуусаагүй. Тэгээд тухайн ажлуудыг дуусгахын тулд бол магадгүй тэр нэмэгдсэн өртөг, зардал, тэр

асуудлуудыг Барилгын хөгжлийн төвөөр заавал ч үгүй магадлуулсан байх гэдэг асуулт тавьж байсан. Тэгээд өнгөрсөн онд тэрийг нь тавья гээд үзсэн. Аудитаар бол бид нар энийг баталгаажуулъя гэдэг асуудлыг тавьж байсан. Одоо барилгын компаниуд буюу барилгачдын холбооныхноос бас Улсын Их Хурлын гишүүдэд Улсын Их Хуралд хандаад байгаа, гомдол гаргаад байгаа асуудал байна. Энэ өөрөө юу вэ гэхээр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг бол Сангийн яамнаас гацаагаад байн гэдэг асуудал тавиад байгаа юм. Яаж байна гэхээр аудит руу өгч байгаа магадлал хийлгэх, тухайн аудитаас зөвшөөрөл өгөх нэрүүдийг Сангийн яамнаас өгөөд байна. Бид нар магадгүй аль 2022, 2023 онд эхэлчихсэн ажлаа энэ 2024 ондоо эсвэл 2025 ондоо эхлүүлчих байсан зүйлийг аудит гэдэг шалтгаар бол хойш нь тавиад, дээрээс нь аудит руу өгөх юу гэдэг юм тур бүтээн байгуулалтуудынх нь нэрүүдийг нь зааж өгч, хойшшуулаад байна гэдэг асуудал гомдол гаргаад байгаа юм. Тэгэхээр уг нь бол бид нарын хувьд чинь бас л нөгөө аль болох л 4, 5 жилийн өмнө ч гэдэг юм уу, 3, 4 жилийн өмнө эхэлчихсэн энэ хөрөнгө оруулалтуудаа аль болох хугацаанд нь дуусгаад, нөгөө тухайн тэр хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үр ашгийг нь бол ингэж хангаж ажиллах л юм байгаад байдаг. Гэтэл баахан царцшихсан, 1 жил царцшихсан, 2 жил цацшихсан энэ ажлууд дээр ер нь яах ёстой юм бэ. Энэ дээр өмнөх төсөв баталж байх үед өнгөрсөн жил бид нар Улсын Их Хурлаас Засгийн газарт бол чиглэл өгсөн. Энэ дээр нэг мэдээлэл өгөөч. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Энэ дээр ер нь 2 чиглэлийн асуудал байгаа юм. Жишээ нь төсөвт өртгүүдийг заавал тусгах ёстай гэдгийг 1 нь шаарддаг, 1 хэсэг нь болохоор хэт өндөр байна гэж энэ дээр бас хяналт тавих чиг үүргээ хангадаг. Тэгэхээр энийг Сангийн яамнаас ганц хүрч чадахгүй ер нь Засгийн газрын аль ч гишүүн, аль ч яам хүрч чаддаггүй 3 байгууллага байдааг юм шүү дээ. Барилга хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв. Зам, тээврийн хөгжлийн төв гээд мөн Уул уурхайн яамны дэргэд мөн ийм төв байдааг. Энэ бол төрийн байгууллагууд биш. Энд тусгай эксперт лиценз бүхий ийм экспертууд ийм үнэлгээчид үнэлгээ гаргаж ирдэг. Энэ дотор үнэхээр аймшигтай, аймшигтай өндөр өсчихсөн өртгүүд нэлээдгүй байдааг. Ялангуяа энэ ковидоос хойш. Энийг шууд төсөвт өртөг тэр нэмэгдлээр нь төсөвт тусгах бол маш эрсдэлтэй. Маш эрсдэлтэй. Энийг бид нар дараагийн шатад нь шалгуулж чадаж байгаа нь бол Аудит. Улсын Их Хурлаас ч ийм үүрэг өгдөг. 1 дүгээрт ийм.

Тэгэхээр бид Аудит руу өгөхөөс өөр арга байхгүй. Аудитлагдаад, тэнд зөвшөөрөөд энэ болж байна гээд ирвэл, 9 сарын 1-ээс өмнө ирснийг нь бид чадан ядан хагаслаад ч хамаагүй багтаагаад, явуулж байгаа. Харин тэр Сангийн яамнаас тэр нэрийн жагсаалт өгдөг гэдэгтэй би огт санал нийлэхгүй байна. Энийг аудитаас л тодорхойлчих хэрэгтэй. Аудит одоо Сангийн яам тэгдэг юм уу, үгүй юм уу гэдгийг өөрсдөө аудиталж байгаа учраас тэдэнд хэн саад болж байна. Энийг хэрвээ тийм асуудлууд байгаа бол бүр хуулийн байгууллагад өгөөд бас шалгуулчих л хэрэгтэй юм байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тэгээд одоо яг бодит мэдээлэл хэрэгтэй байгаа. Тэгэхээр яг аудит дээр гацшихсан гэдэг юм уу, өмнөх хөрөнгө оруулалтуудаас удаашралтай байгаа. Өнгөрсөн Улсын Их Хурал дээрээс чиглэл өгсөн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалттай холбоотойгоор хэчинээн төсөл болоод хэдэн хувь нь яг ийм нөхцөл байдалтай, ямар төсөвт өртөгтэй, дүнтэй асуудлууд гацсан байгаа вэ. Тэгэхээр магадгүй энэ чинь 2026 оных дээр байхгүй бол 2027 оных руу орох уу, үгүй юу гэдэг асуудал руу орох нь байна. Тэгэхээр цаг хугацаа, графикийн хувьд ер нь бас баримжаатай байх ёстай байх. Энэ дээр тайлбар өгөх уу. 2 номер.

Ж.Дэлгэржаргал: Тэмүүлэн гишүүний асуултад хариульяа. Сангийн яам Дэлгэржаргал. Өнгөрсөн оны төсөв батлагдаад Улсын Их Хурлын 52, 54 дүгээр тогтоолын дагуу нэмэлт санхүүжилт үүссэн ажлууд дээр аудит хийлгэж шийдвэрлэх ийм үүрэг чиглэлийг өгсөн. Үүний дагуу 12 сараас эхлээд бид нар яг яамдаас ирсэн хүсэлт, тэр хүсэлт нь өөрөө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүд, мөн дээрээс нь яг энэ нэмэлт санхүүжилтээр магадлал гарсан ийм шаардлагууд байгаа. Энэ ирсэн хүсэлтийн дагуу одоогийн байдлаар бид нар 8 удаагийн албан бичгээр Үндэсний аудитын газарт нийтдээ 195 төслийн 609 тэрбумын нэмэгдлийг хянуулахаар хүргүүлсэн байгаа. 9 сарын 1-нд буюу төсөв өргөн барихаас өмнө аудитаас 100 төслийн 194 тэрбумын нэмэгдлийг хянаж ирүүлснийг төсвийн төсөл тухайн төсөл дээр нь яг нэмэгдлүүдийг тусгаад өргөн барьсан. Өргөн барьснаас хойш Үндэсний Аудитын газраас дүгнэлтүүд бол шууд Улсын Их Хуралд ирж байгаа гэж ойлгож байгаа. Сангийн яаман дээр бол ирснийг бид нар Үндэсний аудитын газрыг Төсвийн байнгын хороонд хүргүүлж байгаа ийм асуудлууд байгаа. Энэ дээр бас цалин, тарифын нэмэгдэлтэй холбоотой асуудал байгаа. Энэ нэмэлт санхүүжилтээс гадна ашиглалтад орчихсон хэр нь цалин, тарифын нэмэгдэл үүсэж байгаа асуудлууд байгаа. Энэ дээр бол Барилга, хот байгуулалтын яамнаас нийтдээ 69 төслийн 35,4 тэрбумын цалин, тарифын нэмэгдлийг аудитаар хянуулах хүсэлтийг ирүүлсэн. Аудитад Сангийн яамнаас хүргүүлээд Үндэсний аудитын газар бол цалин, тарифыг бол Үндэсний аудитын газар хянах боломжгүй гэдэг хариуг ирүүлсэн байгаа. Энэ асуудлыг бид нар Барилга, хот байгуулалтын яаманд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргасны үндсэн дээр бид нар тэгвэл шийдвэрлэх боломжтой байна гэдэг хариуг хүргүүлсэн. Өргөн барихаас өмнө бол Барилга, хот байгуулалтын яамнаас цалин, тарифтай холбоотой нэмэгдлийг төсөв дээр тусгах асуудал бол дахиж ирүүлээгүй байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу. Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Бодлогын хувьд бас төлөвлөлтөө нэгтгэж зангидаа, агуулгаар нь авч явбал яасан юм бэ. Бид нар 475 сая долларыг зээлийн гэрээнд заасан хугацааны дараа 198 сая долларын хүү нэмж төлнө. Тийм учраас бид нар ядаад энийгээ үр ашигтай зарцуулах ёстой. Ийм хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа бол. Хэд хэдэн багцаар хуваасан. 20 сая долларын асуудал дээр асуудалтай байна. Би ХААИС-ийнхаа бараг хүчин чадлыг сайжруулах, тоног төхөөрөмжийн шинэчлэх ажил дээр энэ мөнгөө тавьчихсан бол илүү үр дүнтэй байж дээ л гэж бодож байна. Яагаад гэвэл 1 барилга барина, дахиад урсгал зардал нэмэгдэнэ, дахиад төрийн албан хаагч, орон тоо нэмэгдэнэ. Дараа дараагийн төслийн тэлэлтийн эх үүсвэр болно.

2 дугаарт энэ сургууль, цэцэрлэгийн барилгын төсөвт өртгүүдийг харахаар бүгдийг нь хуваагаад тавьчихсан. Аймгийн сүүлийн жишээ өнгөрсөн 7 хоногт би Эрдэнэтэд бас орон нутгийн томилолтоор ажиллаж байхад 640 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөв дахин магадлалаар ороод, магадгүй магадлалын дүнд янз бүрийн асуудал байхыг үгүйсгэхгүй. Энэ онд хийгдсэн магадлалаар 29 тэрбум болсон байна лээ. Тэгээд өнөөдрийн энэ жишээлбэл 640 хүүхдийн сургуулийн төсөвт өртөг нь 12 тэрбууаар орж ирж байна л даа. Энд ялгаатай зүйлүүд байж болно. Гэхдээ ийм 50 гаруй хувийн зөрүү байгаад бол эргэлзэж байна. Эргээд дуусдаггүй баахан барилгууд, хугацаандаа дуусдаггүй, баахан юм эхэлчихдэг. 2 жилийн дараа магадлал ороод, дахиад үнэ нь өсчихдэг ийм юм руугаа

явчих вий дээ. Ерөнхий гэрээг нийт авах гэж байгаа санхүүжилтийнхээ дүнг бол хүлээн зөвшөөрч батлаад, харин энэ доторх задаргаа юмнуудаа яаж тохирох ёстай юм. Богино хугацаанд тодорхой ажлуудаа 2 жилд нь дуусгаад явах хэмжээнд асуудлаа төлөвлөөд явдаг болмоор байна. 4 жилийн хугацаатай хувааж тавьчхаад, 3 жилийн хугацаатай хувааж тавьчхаад, 2 жилийн дараа магадлал хийгээд, дахиад үнэ өсгөөд байдаг энэ зарчим бас яг энэ хэлэлцээр дээр орж ирэх гээд байна. Тэгэхээр энэнийхээ арын задаргааг анхаарч хараач гэдэг зүйлийг би бас онцгойлон хэл хэлж байна. Тэгээд бид нар Их Хурал дэмжээд, Байнгын хороогоор дэмжээд чуулганаар ороод, дэмжээд явчихаар магадгүй энэ арын задаргаа тэр юу гэдэг юм, нарийвчилсан хаана, ямар ажил хийх юм гэдэг төлөвлөгөө юмнууд нь бол Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд хийгээд явах байх л даа. Тэгээд энэ дээр эргэж яаж хяналт тавих юм. Байнгын хороо энэ дээр тодорхой чиглэл өгч явах ёстай юм уу. Эсвэл Байнгын хорооны тогтоолоор үүрэг даалгавар өгч эргэж хянах юм уу. Ийм хяналттай явахгүй бол өнөөдөр энд баахан яриад гардаг, эргээд нөгөө батлагдсан юмаа дараа нь гүйцэтгэлийг нь үздэг ийм үр ашиггүй юм зарцуулагдчихсан агуулгаараа эргээд явчих вий дээ гэж бас сэтгэл эмзэглэж байна.

Тийм учраас цаашдаа аливаа зээлийн хэлэлцээр дээр, аливаа гаднын буцалтгүй тусламж, дэмжлэг авч байгаа энэ зүйлийг хөрөнгө оруулалтынх нь ач холбогдоор нь үнэхээр эрэмбэлж нэгтгэж зангидах орж ирдэг юман дээр бол бас л учир дутагдалтай байна. Би Тэмүүлэн даргын хэлсэнтэй санал нэг байна. Тэгээд энэ арга аргачлалаа нэг болгож, тодорхой болгож явахгүй бол тэгээд ямар үндэслэлээр орж ирсэн нь мэдэгдэхгүй ийм нөхцөл байдалтай олон асуудлууд байгаа шүү. Би Эдийн засгийн байнгын хороон дээр энэ хэлэлцээрийг дэмжээгүй. Яагаад гэхээр саяын ярьсан асуудлууд, энэ хуваарилалтын асуудлууд, зарцуулалтын энэ оновчгүй төлөвлөлттэй холбоотой асуудал дээр би дэмжээгүй. Гэхдээ Ерөнхий хэлэлцээр нь ерөнхий дүнгээрээ яваад, арынх дээр нь Байнгын хороо энэ дээр тодорхой үүрэг чиглэлтэй ажиллана гэсэн ийм нэмэлт даалгавартайгаар бол дэмжээд явах саналтай байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр бас Байнгын хорооны даргыг бас тодорхой үүрэг чиглэл өгөөсэй гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Төслийг дэмжиж байгаа. Ялангуяа нэг мэдээлэл өгөхгүй бол болохоо байчихлаа. Монгол Улсын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх төсөлтэй холбоотой асуудал. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар Монгол Улсын ажиллах хүчний 2 хүний 1 нь ажиллаж байна. Дотоодын бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ 30 хувь хүрчихлээ. Энэ жил дотоодын бүтээгдэхүүн өсөлтийн 5,6 хувийн өсөлтийн 3,6 хувийг нь дангаараа хангаад эхэллээ. Салбарт юу тулгамдаж байна гэвэл боловсон хүчин, хүний нөөц дутагдаж байна. Ялангуяа байгаа боловсон хүчнээ бид нар чадавхжуулах, бүтээмжийг нь нэмэгдүүлэх, нэмүү өртгийг бий болгох ийм зорилт зайлшгүй бий болж байна. Хөдөө аж ахуйн салбар шинжлэх ухааны олон технологи, ололт амжилтууд нэвтэрч байна. Асар их үнэтэй тоног төхөөрөмж хэрэглэж байна. Одоо манай бэлдэж байгаа боловсон хүчин бэлдэж байгаа энэ систем маань энийг эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байгаа.

Тэгэхээр орчин үеийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадавх бүхий мэргэжилтэй боловсон хүчнийг богино хугацаанд яаралтай олноор нь бэлдэх хэрэгтэй. 4 улирлын хүлэмжийг ажиллуулах, жимс жимсгэнэ, тэр мөөг, мод тарих орчин үеийн фермийн аж ахуй эрхлэх тэр мал эмнэлгийн эм хэрэгсэлтэй харьцах, газар тариаланд орчин үеийн дрон, автоматжуулалт, тэр хиймэл оюун ухааныг

нэвтрүүлэх энэ болгон чинь орчин үеийн мэргэжилтэй боловсон хүчин шаардаад байна. Энийг хийхийн тулд чадавхжуулах том бодлогыг оруулж ирж байгаа юм гэж.

Цаашдаа энэ салбар Монгол Улсыг авч явах байх гэж бодож байгаа юм. Мэдээж уул уурхай гол үүрэг гүйцэтгэсэн хэвээрээ л байх байх. Гэхдээ яг ажил, амьдрал ахуй, орон нутгийн хөгжлийг хангах гол салбараа бид нар чадавхжуулах ийм бодлогыг хийхгүй бол салбар босоод хөдлөөд эхэллээ. Хүний нөөцийн ур чадварын гүн гүнзгий дутагдалд орчихсон байгаа нь харагдаж байна. Олон зуун сая төгрөгийн тэрбумын үнэтэй техник дээр ажиллах хүн байхгүй байна. Чадвартай ур чадвартай мэргэжилтэн гарч чадахгүй байна. Тэгэхээр зайлшгүй энэ салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг чадавхжуулах, орчин үеийн технологийг эзэмшүүлэх, шинэ инновац, технологи нэвтрүүлэх ийм бодлогын асуудлыг Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтраад Хөгжлийн яамаараа энэ асуудлыг хэлэлцүүлээд, ингээд бодлого болгоод Сангийн яам маань оруулж ирж байгаа юм. Ийм бодлого явж байгаа гэдгийг эрхэм гишүүд ойлгоорой.

Ингээд нэгэнт төсөв өөрөө хязгаарлагдмал байгаа бид чинь сүүлийн 2 жил ялангуяа гадаад зээлийн ашиглалтыг Их Хурлаас нэлээн хязгаарлачихсан. Тэгэхээр үүгээр бид боловсролын тулгамдсан олон асуудлаа шийдэх боломж үүсэж байна. Эрүүл мэндийнхээ асуудал үндсэнд нь шийдэх бололцоо үүсэж байна. Ингээд ялангуяа онцгой асуудал болдог сөрөн тэсвэрлэх чадавх, гамшигтай тэмцэх асуудлыг бид нар босгох бололцоо гарч байна. Энэ дотор байгаа багахан 10 хувь хүрэхгүй шүү дээ энэ дүн. 4, 5 хувь нь байна уу, үгүй юу. Энэ мэргэжилтэй болсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах энэ хөтөлбөр дээр дэмжлэг үзүүлээч ээ гэж хүсэж байгаа.

Г.Тэмүүлэн: Номин гишүүн үг хэлнэ.

Ч.Номин: Надад 2 санал байна. Энэ нийт хөрөнгийн ашиглалт буюу зээлийн ашиглалт 68 хувьтай байгаа юм байна лээ. Би асуугаад, надад сая хариулахгүй байна. Ингээд түрүүн өөрсдөө хэлсэн коммитмент фий буюу хөрөнгө хадгалсны зардалдаа жилд бид нар бараг 50 тэрбум төгрөг зарцуулаад, цаашдаа явахаар байна. Бид нар шинэ зээл тусlamж оруулж ирэхээсээ илүүтэй энэ зээлийн ашиглалтаа сайжруулах буюу яаж хурдтай энэ төслийг хийж хэрэгжүүлэх вэ гэдэг дээрээ анхаарах нь бидний хувьд хамгийн чухал байгаа. Ийм ч учраас энэ яам дээр нэгдсэн төслийн нэгж байгуулна гэдэг бол маш буруу зүйл шүү. Яаманд энэ нэгдсэн байдлаар төслүүдийг хэрэгжүүлээд аваад явчих яг тусгай мэргэжлийн хүн хүмүүс бол ховор. Мэдээж манай төрийн албан хаагч нар сайн. Гэхдээ энэ хүмүүст бол ийм боломж, бололцоо ч байдаггүй. Өмнөө байгаа цаасныхaa араас ч гарч ирж чаддаггүй. Тэгээд энийг 200 хүн хэмнэж байна гээд бүхэл бүтэн 400, 500 сая долларын зээлийнхээ ашиглалтыг, дээрээс нь төслийн хэрэгжилтээ удаашруулах ийм нөхцөлд орчих вий гэдгийг би бас анхааруулж хэлмээр байна.

Миний хувьд зарчмын санал байна. Энэ хөдөө аж ахуйн салбарыг чадавхжуулах гэдэг бол зөв. Хүний нөөцөө бэлдэх нь чухал. Тэгэхдээ энэ бол их сургууль бариад, тэр сургуульд хүн сурснаар болдоггүй. Зүгээр л ерөөсөө энэ салбарыг л чөлөөтэй өрсөлдөх боломжийг бий болгох ёстой. Бид нар уул уурхайн салбартай адилхан хөдөө аж ахуйн салбарт цалин олгодог болж байж ийшээ хүмүүс ирнэ үү гэхээс сургууль барьснаар эд нар нэг их тийм болохгүй. Угаасаа аж ахуйн нэгжүүд өөрсдөө энэ хүмүүсээ чадавхжуулаад аваад явах боломжтой байгаа. Хамгийн гол нь л чөлөөт өрсөлдөөнийг бий болгох нь хамгийн чухал байгаа.

Энэ дээр Дэлгэржаргал аа, би энэ яг төсвийн номын 114 дүгээр хуудас, 115 дугаар хуудсан дээр байгаа гадаадын зээл, тусламжаар оруулах юуг асууж байгаад асуусан шүү дээ. Энэ дээр байгаагаас өөр байсан учраас би асуусан.

Миний хувьд бол зарчмын зөрүүтэй санал байгаа. Юу вэ гэхээр би Тэмүүлэн гишүүнтэй санал нэг байгаа. Нэг мөсөн боловсролынхоо чиглэл рүү хандсан нь дээр биш юм уу. Ийм учраас Азийн хөгжлийн банкны эхний заалт дээр байгаа энэ боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг хуучин хэлбэрээр нь буюу 150 сая долларынх нь хэмжээгээр нь явуулаад, Дарханд хийгдэх гэж байгаа Хөдөө аж ахуйн коллежийг хасах ийм зарчмын саналтай байна.

Г.Тэмүүлэн: Үг хэлэх юм уу. Наранбаяр сайд үг хэлье.

П.Наранбаяр: Уучлаарай энэ дээр бас тайлбар хэлсэн нь зүйтэй байна. Энэ 150 саяын 20 сая гэдэг нь ер нь мэргэжлийн боловсролыг дэмжих гэж анх орж ирсэн. Энэ нөгөө Азийн хөгжлийн банкны өөрсдийнх нь зээл олгож байгаа талынх нь өөрсдийнх нь санал шүү. Тэгээд ийм хэмжээнд ингээд мэргэжлийн боловсролыг дэмжих, бас сургалтыг нь дэмжих ийм юм оруулахгүй бол бас энэ нийт зээл дээр өөрсдөд нь бас зөвхөн сургууль, цэцэрлэгийн барилга гэдэг юмыг бол барих боломжгүй гэсэн юмыг Азийн хөгжлийн банк тал нь өөрсдөө Монгол талд санал тавьсан. Ийм байгаа.

Тэгээд энэ болохоороо ер нь бол дадлагын баазыг Сэлэнгэд байгуулж, ер нь тэнд Дархан-Уул аймгийн Политехникийн коллежийг түшиглэсэн гол сургалтууд, тэнд чинь 35 мэргэжлээр жилдээ 1900 мэргэжлийн ажилтан бэлддэг, богино хугацаанд бэлддэг ийм том төсөл хөтөлбөр юм. Ингэснээр түрүүн миний хэлсэнчлэн эдийн засгийн ийм үр ашгууд гарна гэж харж байгаа. Тэгэхээр ийм учиртай. Энэ өөрөө боловсролын бас нэг салшгүй хэсэг, мэргэжлийн боловсрол хэсэг нь. Бид энэ жилээс бас мэргэжлийн боловсролыг түлхүү дэмжье гээд элсэлтийг нь нэмэгдүүлж, хувьсах зардлыг нь өргөн барьсан шүү дээ. Бас төсвийн төсөлд оруулж ирэхдээ жилдээ 20 мянга байсныг 26 мянга болгож 6 мянгаар нэмэгдүүлж орж ирж байгаа. Ер нь мэргэжлийн боловсролд бол бид онцгой анхаарахгүй бол бүх хүн их, дээд сургууль төгсөөд байх ийм бас боломжгүй. Бүх хүн шууд о ахлах сургуулиа төгсөөд, хөдөлмөрийн зах зээл дээр гарах боломжгүй. Тэгэхээр ийм гартаа өөрийн гэсэн мэргэжлийн ийм чадвартай хүмүүсийг гаргах нь мөн хөдөө аж ахуй дээр шууд ажиллах ийм хүмүүсийг гаргах нь их чухал. Богино хугацаанд олон хүнийг бэлдэх гэдэг нь өөрөө чухал учраас энэ орж ирж байгаа юм гэдгийг тайлбарлаж хэлэх гэсэн юм.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр зээлийн хэлэлцээрийг 3 Байнгын хороо бол хэлэлцлээ. Эдийн засгийн байнгын хороо хэлэлцээд, санал, дүгнэлтээ бол хүргүүлсэн. Эдийн засгийн байнгын хороо нь дээр ч яригдсан, гишүүдийн хэлсэн зээлийн хэлэлцээртэй холбоотой хэд хэдэн саналууд гарсан. Энийг бас сая Очирбат гишүүн уншиж танилцуулсан байгаа. Ерөөсөө гол энэ Байнгын хороон дээр ч, Төсвийн байнгын хороо, манай Байнгын хороон дээр ч яригдаж байгаа гол үндсэн асуудал бол ерөөсөө энэ зээлийн хэлэлцээрийн үр ашиг, эрэмбэ дараалалтай холбоотой асуудал, хөрөнгө оруулалтын оновчтой хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг бол гаргаж ирж тавиад байна.

Тэгэхээр би бол нэг талдаа саяын гишүүдийн саналыг зээлийн хэлэлцээрийг хэлэлцээр хийж байгаа Засгийн газрын зүгээс бас онцгой анхаарч ажиллаарай. Энэ бол 1 дүгээр зөвшилцөх эсэх асуудал дөнгөж орж ирж байна. Буцаад Их Хурал руу

боловод Байнгын хороонууд руу соёрхон батлуулахаар орж ирэх ёстой. Мэдээж Азийн хөгжлийн банк бол өөрөө шаардлагаа тавьдаг нь бол ойлгомжтой асуудал. Тэгэхээр яг өөрсдийнх нь тэр шаардлагын дагуу нарийвчилсан үнэлгээ хийгээд ирэхээр, энэ хөрөнгө оруулалтууд дээр тодорхой дүн шинжилгээ хийгээд гэдэг юм уу, тодорхой үнэлэлт дүгнэлт өгөөд ирэхээр тодорхой хэмжээнд, магадгүй, энэ нарийвчилсан үнэлгээтэй холбоотойгоор бол төслүүд хөдлөх, өөрчлөгдөх тийм асуудал бол үүсдэг. Тэгэхээр энэ дээр бол ямар нэг байдлаар гол онцолж хэлж байгаа зүйл бол дийлэнх сая санал хэлсэн гишүүдийн зүйл бол боловсролын салбар дээр, эрүүл мэндийн салбар дээр энэ хөрөнгө оруулалтуудыг бууруулахгүй байх, тэр дундаа сургууль, цэцэрлэгийн тоог бууруулахгүй, нэмэгдүүлэх бодлого бариарай гэсэн энэ саналыг бол хаана хаанаа хэлж байна гэж харж байгаа.

Дээрээс нь энэ хөрөнгө оруулалтын төсөвт өртөгтэй холбоотой асуудлуудыг бас гаргаж ирж тавьж байна. Үүрийнтуяа гишүүн бас санал хэлж байна. Магадгүй байх ёстой хэм хэмжээнээс илүү өндөр өртөгтэй, зардалтай гэдэг юм уу ийм зүйлүүд байна гэдэг асуудлыг бол яриад байгаа юм. Тэгэхээр энэ энэ дээр бол яг саяын тэр хөрөнгө оруулалтын хуваарилалт болоод хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөж, эрэмбэ дараалалтай холбоотой асуудлууд дээр бол хэлэлцээр хийг тал Засгийн газрын зүгээс онцгой анхаарч, Азийн хөгжлийн банктай энэ хэлэлцээрээ бас илүү сайжруулж, соёрхон батлахаар оруулж ирэхдээ анхаарч орж ирэх ёстой юм шүү гэсэн саналыг бол хэлэх байна.

Тэгээд үндсэндээ Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо болоод Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан байнгын хорооны санал, дүгнэлтийг бид нар Засгийн газарт дүгнэлтүүдийг хүргүүлнэ. Мөн энэ хуралдаанаас гарч байгаа хуралдааны тэмдэглэлийг бол хүргүүлнэ. Тэгэхээр саяын тэр гишүүдийн онцолж хэлсэн бодлогын шинжтэй асуудлуудыг бол эрэмбэлж шийдвэрлэх гэдэг энэ саналыг бол онцолж, санал, дүгнэлт болоод хуралдааны тэмдэглэл дээр өгөх болно гэдгийг болбол хэлэх байна.

Тэгээд Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, мөн Сангийн яам, Засгийн газрын зүгээс, Онцгой байдлын зүгээс бас эдгээр асуудлууд дээр хэлэлцээрээ үр ашигтай байдлаараа эцэслэж орж ирээрэй гэдэг зүйлийг бас эцэст нь дүгнэж хэлэх байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулна. Байнгын хорооны гишүүдийг дуудаарай. Ирц хэдтэй байна. Гишүүд хуралдаандаа орж ирээрэй. Санал хураалт явуулахад бэлэн болсон байна. Нийт 35 гишүүн ирцэд орсон байна. Ямар ч байсан санал хураалтын бэлэн байдлыг 1 дүгээрт хангаадахъя. Тэгээд бэлэн байдлаар ирцээ аваадахъя. Гишүүд хуруугаа хийгээд, бэлэн байдлаа эхлээд хангаадахъя. Санал өгөх гишүүд хуруугаа уншуулаарай. 14 бэлэн байна. Бэлэн бус 21. Гишүүдийг дуудаарай. 2 Байнгын хорооны ажлын алба гишүүд рүү нэг бүрчлэн залгаарай. Ямар ч байсан 4-5 гишүүд орж ирж байж ирц бүрдэх юм байна. 17 болсон байна. Булгантuya гишүүн орсон. Бүгд орсон байна. Эрдэнэболд гишүүн бэлэн байдалд ороорой. Бэлэн байдалд 21 гишүүн орж ирсэн байна. Одоо санал хураахад бэлэн болсон байна.

Тэгээд гишүүдийн хэлж байгаа саналыг дахиж анхаараарай. 2 Байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлт дээр тодорхой нөхцөлтэйгөөр явуулж байна шүү. Үр ашиг, оновчтой байдал, хуваарилалт эдгээр асуудлууд дээр бол сайжруулж анхаарах зүйлүүд байна гэдэг зүйлийг хэлээд байгаа шүү. Ингээд санал хураалтыг явуулна.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулах нь байна. Зөвшилцэх эрхийг нь олгоё гэсэн санал хураалт. Санал хураалтад 35 гишүүн оролцож, 21 гишүүн дэмжиж, 60 хувиар дэмжигдсэн байна.

Ингээд энэ асуудлыг хэлэлцэн талаарх 2 Байнгын хорооны хамтарсан тэмдэглэл болоод санал, дүгнэлтийг бол Засгийн газарт хүргүүлэхээр байгаа. Ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал буюу “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцэж дууслаа. Ингээд 2 Байнгын хорооны хамтарсан хурлаар хэлэлцэх асуудал дууссан байна. Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.49 цаг.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ